

Албан бус орчуулга



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМААР ТӨЛӨӨЛҮҮЛЭН
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

БОЛОН

**МЯНГАНЫ СОРИЛТЫН КОРПОРАЦИАР ТӨЛӨӨЛҮҮЛЭН
АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС**

ХООРОНДЫН

ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**ГАРЧИГ**

| | |
|---|----|
| 1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮЛЭЭХ ЕРӨНХИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА..... | 4 |
| 1.1 Хэсэг: Тодорхойлолт..... | 4 |
| 1.2 Хэсэг: Засгийн газрын үүрэг. | 4 |
| 1.3 Хэсэг: Монголын МСС-ийн үүрэг..... | 6 |
| 2 ДУГААР ЗҮЙЛ. ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭ..... | 8 |
| 2.1 Хэсэг: Хэрэгжилтийн төлөвлөгөө. | 8 |
| 2.2 Хэсэг: Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөө. | 10 |
| 2.3 Хэсэг: Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө..... | 10 |
| 2.4 Хэсэг: Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн төлөвлөгөө. | 10 |
| 2.5 Хэсэг: Нийгэм, жендэрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах төлөвлөгөө..... | 11 |
| 2.6 Хэсэг: МСК-ийн Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа, Буцалтгүй тусламж олгох МСК-ийн зөвшөөрөл. | 11 |
| 2.7 Хэсэг: Нийлүүлэгчдэд хүргэх мэдэгдэл; Компакт гэрээний зарим зүйл заалтыг түүнд тусгах..... | 12 |
| 2.8 Хэсэг: Тайлан; Мэдэгдэл. | 12 |
| 2.9 Хэсэг: МСК-аас зөвшөөрөл авах шаардлагатай гүйлгээ..... | 13 |
| 2.10 Хэсэг: Зарим тодорхой этгээдийн Хэрэгжилтэд гүйцэтгэх үүрэг | 14 |
| 2.11 Хэсэг: Олон нийтэд хүргэх мэдээлэл, Ил тод байдал..... | 16 |
| 2.12 Хэсэг: Брэнд, Брэндийг ашиглах. | 17 |
| 2.13 Хэсэг: Татвараас чөлөөлөх ажлыг хэрэгжүүлэх. | 18 |
| 2.14 Хэсэг: Засгийн газрын оруулах хувь хэмжээ..... | 18 |
| 2.15 Хэсэг: Засгийн газрын хүлээх нэмэлт үүрэг..... | 18 |
| 3 ДУГААР ЗҮЙЛ. МСК-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТ | 19 |
| 3.1 Хэсэг: Зарцуулалтын үйл явц..... | 19 |
| 3.2 Хэсэг: Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтээс хийх Зарцуулалтад тавигдах урьдчилсан болзолт нөхцөлүүд. | 21 |
| 3.3 Хэсэг: Хөтөлбөрийн санхүүжилтээс хийх эхний Зарцуулалтад тавигдах урьдчилсан болзолт нөхцөлүүд. | 21 |
| 3.4 Хэсэг: Хөтөлбөрийн санхүүжилтээс хийх Зарцуулалт бүрт тавигдах урьдчилсан болзолт нөхцөлүүд. | 22 |
| 3.5 Хэсэг: Зөвшөөрөгдсөн зардал. | 23 |
| 4 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЭНЭХҮҮ ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, КОМПАКТ ГЭРЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ҮЙЛЧЛЭЛИЙГ ТҮР ЗОГСООХ, ДУУСГАВАР БОЛГОСНООР ГАРАХ ҮР ДАГАВАР | 23 |
| 4.1 Хэсэг: Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох. | 24 |
| 4.2 Хэсэг: Компакт гэрээг хүчингүй болгох, үйлчлэлийг түр зогсоох, эсхүл дуусгавар болгосноор гарах үр дагавар. | 24 |
| 5 ДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ЗААЛТУУД..... | 26 |
| 5.1 Хэсэг: Төлөөлөгчид..... | 26 |
| 5.2 Хэсэг: Харилцаа холбоо. | 26 |

| | |
|---|----|
| 5.3 Хэсэг: Засгийн газрийн эрх, үүргийг шилжүүлэх..... | 26 |
| 5.4 Хэсэг: Нэмэлт өөрчлөлт; Эрх үүргээс татгалзах. | 26 |
| 5.5 Хэсэг: Хавсралтууд..... | 26 |
| 5.6 Хэсэг: Үл нийцэл. | 26 |
| 5.7 Хэсэг: Энэхүү Гэрээг хүчингүй болгох..... | 26 |
| 5.8 Хэсэг: Үйлчлэл хэвээр хадгалагдах. | 27 |
| 5.9 Хэсэг: МСК-д хүргүүлсэн мэдээлэл..... | 27 |
| 5.10 Хэсэг: Хэрэглэх хууль. | 27 |
| 5.11 Хэсэг: Гарын үсэг. | 27 |
| I хавсралт. Нэр томьёо | 29 |
| II хавсралт. Хөтөлбөрийн санхүүжилтэд тавигдах нэмэлт урьдчилсан болзолт нөхцөлүүд | 32 |
| III хавсралт. Засгийн газрын оруулах хувь хэмжээ | 35 |
| IV хавсралт. Засгийн газрын оруулах хувь хэмжээг зарцуулах зарчим | 36 |
| V хавсралт. Татварын хуваарь..... | 38 |

-----oO-----

ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

ОРШИЛ ХЭСЭГ

Энэхүү ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ (энэхүү “Гэрээ” гэх)-г Гадаад харилцааны яам (“Яам” гэх)-аар төлөөлүүлэн Монгол Улсын Засгийн газар (“Монгол Улс” эсхүл “Засгийн газар” гэх) болон Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын байгууллага болох Мянганы сорилтын корпораци (“МСК” гэх)-р төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улс (тус бүртээ “Тал,” хамтдаа “Талууд” гэх)-ын хооронд байгуулав.

Засгийн газар болон МСК-аар төлөөлүүлэн Америкийн Нэгдсэн Улс нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах зорилго бүхий Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан МСК-аас Засгийн газарт 350,000,000 (гурван зуун тавин сая)-аас илүүгүй дүн бүхий ам.долларыг олгох ерөнхий нөхцөлүүдийг заасан Мянганы сорилтын Компакт гэрээ (“Компакт гэрээ” гэх)-г 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан болохыг санаж;

Засгийн газар нь Компакт гэрээ болон холбогдох бусад гэрээний дагуу хүлээх зарим тодорхой эрх, үүргээ Монголын Мянганы сорилтын санд шилжүүлсэн болохыг санаж;

Талууд Компакт гэрээ болон Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх нөхцөлүүдийг улам бүр нарийвчлан тогтоох хүсэлтэй байгаагаа нотолж;

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮЛЭЭХ ЕРӨНХИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

1.1 Хэсэг Тодорхойлолт.

Энэхүү Гэрээнд том үсгээр эхлэн бичсэн бөгөөд тусгайлан тодорхойлоогүй нэр томъёо нь Компакт гэрээнд заасан утгыг илэрхийлнэ. Том үсгээр эхлэн бичсэн бусад нэр томъёо нь Хавсралт 1-д заасан утгыг илэрхийлнэ.

1.2 Хэсэг Засгийн газрын үүрэг.

(a) Засгийн газрын хүлээх үүрэг хариуцлага. Засгийн газар нь Компакт гэрээ, энэхүү Гэрээ болон бусад Нэмэлт гэрээгээр хүлээх аливаа үүрэг хариуцлагаа (үүнд, Компакт гэрээний хугацаа дууссаны дараах аливаа үйл ажиллагаа, аудит, эсхүл бусад үүрэг хариуцлага мөн багтана) хэрэгжүүлэх, түүнчлэн Монголын МСС болон бусад этгээд (тус бүр “Эрх бүхий байгууллага” гэх)-эд өөрийн өмнөөс Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, хяналт тавих чадамжийг олгоход хүрэлцэхүйц хэмжээний эрх, үүргийг шилжүүлэхэд шаардлагатай эсхүл зохистой бүх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.

(b) Засгийн газрын үүрэг амлалт. Засгийн газар дараах баталгааг гаргаж байна. Үүнд:

(i) Хөрөнгө хураах; Барьцаалах, эсхүл аливаа бусад Хязгаарлалт тавих. Засгийн газар нь МСК-аас бичгээр урьдчилан зөвшөөрснөөс бусад тохиолдолд (А) Хөтөлбөрийн аливаа өмч хөрөнгийг хураах, цуцлах, битүүмжлэхгүй байх, улмаар одоо хүчин төгөлдөр үйлчилж буй болон цаашид хүчин төгөлдөр болох Монгол Улсын аливаа хууль тогтоомжийн дагуу ийнхүү хураах, цуцлах, битүүмжлэх нөхцөл үүсгэхгүй байх, (В) Хөтөлбөрийн аливаа өмч хөрөнгийг барьцаа болгохгүй, шүүхийн аливаа шийдвэрийг биелүүлэх зорилгоор битүүмжлэх, зарж борлуулахгүй (тус бүр **“Барьцаа”** гэх) байхад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна. МСК-ийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр хөрөнгө барьцаалах шийдвэр гарсан тохиолдолд Засгийн газар нь уг барьцааг шуурхай чөлөөлүүлэх хүсэлт гаргах бөгөөд давж заалдах боломжгүй, эцсийн шатны шүүхийн шийдвэрээр энэхүү Барьцааг шаардсан тохиолдолд Засгийн газар шаардлагатай хэмжээний төлбөрийг төлж, хөрөнгийг чөлөөлүүлэх арга хэмжээг авах ба **ингэхдээ** МСК-ийн санхүүжилт, Засгийн газрын оруулах хувь хэмжээ, эсхүл Хөтөлбөрийн аливаа хөрөнгийг ашиглаж үл болно.

(ii) Үл хөдлөх хөрөнгөөс бүрдэх Хөтөлбөрийн хөрөнгийг бусдад шилжүүлэх. Засгийн газар нь МСК-аас бичгээр урьдчилан зөвшөөрснөөс бусад тохиолдолд үл хөдлөх хөрөнгөөс бүрдэх Хөтөлбөрийн аливаа хөрөнгийг (А) Бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түрээслүүлэх, эсхүл давхар түрээслүүлэхгүй байх, эсхүл (В) Зарж борлуулах, хандивлах, эсхүл өөр бусад байдлаар бусдад шилжүүлэхгүй байхад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна. Түүнчлэн, Компакт гэрээний хугацаа дууссанаар, эсхүл хугацаанаасаа өмнө цуцлагдсан тохиолдолд Монголын МСС-ийн авч үлдсэн үл хөдлөх хөрөнгөөс бүрдэх Хөтөлбөрийн хөрөнгө нь хаалтын хугацааны сүүлийн өдрөөс хойш 5 (таван) жилийн хугацаанд Хөтөлбөрийн хаалтын зааварчилгааны дагуу МСК-ийн буцаан сэргээх эрхэд хамаарах бөгөөд энэ таван жилийн дотор Засгийн газар нь үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулах, Хөтөлбөртэй, эсхүл Хөтөлбөрийн зорилтыг урагшлуулахтай холбогдолгүй аливаа зориулалтаар ашиглахыг хүсвэл тухайн үл хөрөнгөд эзлэх МСК-ийн хувийн нөхөн төлбөрийг тухайн үеийн зах зээлийн ханшийн дагуу хийж авна.

(iii) Байгаль орчин, нийгмийн үзүүлэлтүүд. Засгийн газар болон МСК харилцан бичгээр өөрөөр тохироогүй тохиолдолд, Засгийн газар нь Компакт гэрээний дагуу МСК-ийн хөрөнгөөр хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь (шууд эсхүл шууд бусаар) санхүүжүүлсэн Төсөл, Үйл ажиллагаануудыг МСК-ийн *Байгаль орчны зааварчилгаа*, түүний дотор Олон улсын санхүүгийн корпорацийн *Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандартууд* (тухай бүр хүчин төгөлдөр үйлчилж буй **“ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартууд”** гэх)-д зааж, МСК-ийн Байгаль орчны зааварчилгаанд ишлэл болгон оруулсан байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн стандартуудад нийцүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна. Түүнчлэн Засгийн газар нь Компакт гэрээтэй үл нийцэхээс бусад тохиолдолд Төсөл, Үйл ажиллагаануудыг Монгол Улсын байгаль орчны холбогдох бүх хууль тогтоомж, тусгай болон бусад зөвшөөрөлд нийцүүлэх арга хэмжээг авна. Монгол Улсын байгаль орчны хууль тогтоомж болон Компакт гэрээгээр шаардлага болгож буй стандартуудын хооронд үл нийцэл гарсан тохиолдолд Засгийн газар нь тэдгээрээс аль чанга стандартыг сонгон баримтлуулна. МСК-аас бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Засгийн газар нь ямарваа нэг Төсөл, Үйл ажиллагааны Санхүүгийн дэлгэрэнгүй төлөвлөгөөнд тусгайлан суулгаагүй, эсхүл суулгасан санхүүжилтээс давсан дүн бүхий байгаль орчин, нийгмийн эрсдлийг

саармагжуулах арга хэмжээ (үүнд, нүүлгэн суурьшуулах арга хэмжээ мөн багтана)-ний бүх зардлыг санхүүжүүлнэ.

(iv) Жендэр, нийгмийн оролцоог хангах. Засгийн газар болон МСК харилцан бичгээр өөрөөр тохироогүй тохиолдолд, Засгийн газар нь Компакт гэрээний дагуу МСК-ийн хөрөнгөөр хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь (шууд эсхүл шууд бусаар) санхүүжүүлсэн Төсөл, Үйл ажиллагаануудыг *МСК-ийн Жендэрийн бодлого* болон *МСК-ийн Жендэрийн оролцоог хангах зааварчилгаанд* нийцүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна. Монгол Улсын жендэр, нийгмийн оролцооны тухай хууль тогтоомж болон Компакт гэрээгээр шаардлага болгож буй стандартуудын хооронд үл нийцэл гарсан тохиолдолд Засгийн газар нь тэдгээрээс аль чанга стандартыг сонгон баримтлуулна.

1.3 Хэсэг Монголын МСС-ийн үүрэг.

(a) Монголын МСС-ийн чиг үүрэг.

(i) Компакт гэрээний 3.2(b) дэх хэсэгт заасны дагуу Засгийн газар нь эрх зүйн чадамж бүхий, бие даасан хуулийн этгээд болох Монголын Мянганы сорилтын сан ("**Монголын МСС**" гэх)-г Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, улмаар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, уг ажилд хяналт тавихтай холбоотой Засгийн газрын эрх, үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх, түүний дотор Төсөл болон Төслийн хүрээнд хэрэгжих Үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх, төсөв, эх үүсвэрийн зарцуулалтыг төлөвлөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах ("**Оноосон эрх, үүрэг хариуцлагууд**" гэх) үндсэн төлөөлөгчөөр томилсон болно. Компакт гэрээ болон энэхүү Гэрээний дагуу, эсхүл эдгээртэй холбогдуулан Засгийн газарт хүлээлгэсэн аливаа үүргийн гүйцэтгэлийг Засгийн газар ямар ч тохиолдолд хариуцна гэдгийг Талууд үүгээр тэмдэглэв.

(ii) Засгийн газар нь Компакт гэрээний хугацаанд Монголын МСС-г сайтар зохион байгуулалттай, хангалттай боловсон хүчинтэй, Оноосон эрх, үүрэг хариуцлагуудыг биелүүлэхэд шаардлагатай эрх зүйн чадамжтай байлгах бүхий л арга хэмжээг авна.

(iii) Хөтөлбөрийн зааварчилгаанд "Хариуцагч этгээд" гэж заасныг Монголын МСС хэмээн ойлгох бөгөөд "Хариуцагч этгээд"-д Хөтөлбөрийн зааварчилгааны дагуу ногдуулсан бүх үүрэг хариуцлагыг Монголын МСС-д хамааруулан ойлгоно.

(b) Монголын МСС-тай холбогдуулан өгч буй Засгийн газрын нэмэлт үүрэг амлалтууд. Засгийн газар нь МСК-д дараах амлалтуудыг өгч байгаа болно. Үүнд:

(i) Эрх мэдэл. Монголын МСС нь (А) нийт Оноосон эрх, үүргийн хүрээнд Засгийн газрыг төлөөлөх, (В) энэхүү Гэрээ, Компакт гэрээ болон аливаа бусад Нэмэлт гэрээ, Хөтөлбөрийн зааварчилгааны дагуу байгуулсан гэрээ, хэлэлцээр, гэрчилгээ, бусад баримт бичиг тус бүрийн гүйцэтгэлийг хангаж, хүргүүлэх, (С) энэхүү Гэрээ, Компакт гэрээ болон аливаа бусад Нэмэлт гэрээ, Хэрэгжүүлэх захидал, Хөтөлбөрийн зааварчилгааны дагуу байгуулсан аливаа бусад гэрээ, хэлэлцээр, гэрчилгээ, бусад баримт бичиг тус бүрийн дагуу хүлээсэн өөрийн үүргийг биелүүлэх эрх мэдэлтэй байна.

(ii) Засгийн газрын үүрэг хариуцлага. Монголын МСС нь (А) Оноосон эрх, үүрэг (Компакт гэрээ, энэхүү Гэрээ, Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн тухай хэлэлцээр, эсхүл аливаа бусад Нэмэлт гэрээгээр Монголын МСС-д

ногдуулсан бүх үүрэг хариуцлагыг оролцуулан)-ийг биелүүлэхдээ техникийн, санхүүгийн, менежментийн зохих туршлагад тулгуурлан, Компакт гэрээ, энэхүү Гэрээ, Буцалтгүй тусламж, түүний гүйцэтгэлийн тухай хэлэлцээр, аливаа бусад Нэмэлт гэрээ болон Хөтөлбөрийн зааварчилгаа тус бүрт нийцүүлэн, хянамгай, үр бүтээлтэй, шаргуу хандаж ажиллах, (B) энэхүү Гэрээний 2.10 дахь хэсэгт заасан, эсхүл Хэрэгжүүлэгч байгууллагатай холбоотойгоос бусад үед, МСК-аас бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй бол Оноосон эрх, үүргийг ямарваа байдлаар шилжүүлэхгүй ба (C) МСК-аас бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй бол Оноосон эрх, үүргээс өөр бусад үйл ажиллагаа, үүрэг хариуцлагыг хүлээн авч, хэрэгжүүлэхийг хориглоно.

(iii) Засгийн газрыг төлөөлөх. Монголын МСС нь өөрийн хүргүүлж буй аливаа гэрээ, хэлэлцээр, гэрчилгээ, бусад баримт бичигт Засгийн газрыг төлөөлөн оролцож буй тохиолдолд ийнхүү төлөөлж буй талаараа МСК-д албан ёсоор мэдэгдэхийн өмнө холбогдох бүх Эрх бүхий байгууллагад мэдэгдэн баталгаажуулсан байна.

(iv) Хараат бус байдал. Засгийн газар нь (A) Эцсийн шатны, давж заалдах боломжгүй шүүхийн шийдвэрээс бусад тохиолдолд Монголын МСС-ийн ямар ч шийдвэрт Засгийн газрын аливаа байгууллагаас өөрчлөлт, нэмэлт оруулах, зүй бусаар нөлөөлөх, цуцлахгүй байх, (B) Компакт гэрээ болон энэхүү Гэрээнд зааснаас бусад тохиолдолд Монголын МСС-ийн эдлэх эрх мэдлийг нэмэгдүүлэх, хязгаарлах, эсхүл өөр бусад байдлаар өөрчлөхгүй байхад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

(v) Монголын МСС-ийн дотоод засаглал. Монголын МСС нь захиргаа, үйл ажиллагааны цар хүрээ, нийт ажилтнуудын ажил эрхлэх ерөнхий нөхцөлийг заасан дотоод дүрэм, журам ("**Журам**" гэх) болон хүний нөөцийн гарын авлага ("**Хүний нөөцийн гарын авлага**" гэх)-ыг тус бүр агуулга, хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, батлан баримтлана. Монголын МСС нь удирдлага, үйл ажиллагаагаа Суурь баримт бичгүүд (Журмыг оролцуулан) болон Засаглалын зааварчилгаанд нийцүүлэн явуулах бөгөөд МСК-тай өөрөөр харилцан тохироогүй тохиолдолд Хүний нөөцийн гарын авлагыг дор хаяж жил тутам хянан үзэж, шинэчилж байна.

(vi) Санхүүжилт бүхий гэрээ, Ерөнхий заалтуудын хавсралт. Монголын МСС нь МСК-ийн хөрөнгөөр, эсхүл Засгийн газрын оруулах хувь хэмжээний хөрөнгөөр (шууд болон шууд бусаар) санхүүжүүлж буй гэрээ (тус бүрийг "**Санхүүжилт бүхий гэрээ**" гэх) болгоны хувийг, МСК уг гэрээтэй холбогдуулан аливаа эрх эдэлж буй эсэхээс үл хамааран, Санхүүгийн төлөөлөгч (МСК-аас хүссэн тохиолдолд МСК-д мөн)-д хүргүүлнэ. МСК-аас өөрөөр урьдчилан зааварласнаас бусад тохиолдолд Монголын МСС нь Санхүүжилт бүхий гэрээ тус бүрт (A) тухайн гэрээг байгуулж буй этгээд (тус бүрийг "**Нөгөө тал**" гэх) нь (i) Ерөнхий заалтуудын хавсралт, (ii) Ерөнхий заалтуудын хавсралтад заасан нөхцөлүүдийн биелэлттэй холбогдуулан МСК-аас ирүүлсэн аливаа зааварчилгааг Монголын МСС-аас өгсөн бусад зааварчилгаанаас үл хамааран биелүүлж байх нөхцөлийг оруулсан байх, (B) Нөгөө тал нь Ерөнхий заалтуудын хавсралт, эсхүл МСК-аас ирүүлсэн холбогдох зааварчилгааг даган биелүүлээгүй тохиолдолд Санхүүжилт бүхий гэрээг цуцлах эрхийг Монголын МСС-д олгосон байх шаардлагатай.

(vii) Даатгал, Гүйцэтгэлийн баталгаа. Монголын МСС нь МСК-ийн шаардлагад нийцүүлэн Хөтөлбөрийн нийт хөрөнгийг даатгуулж (өөрийн даатгалаар дамжуулан), Хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэл, хохирлоос хамгаалах өөр бусад даатгалд хамруулах зохицуулалтуудыг мөн хийх бөгөөд ингэхдээ Нийлүүлэгчдийг зохих ёсоор даатгуулсан байхыг шаардаж, гүйцэтгэлийн баталгаа болон холбогдох бусад баталгааг мөн гаргуулж авна. МСК-аас урьдчилан зөвшөөрсний дагуу МСК-ийн санхүүжилтийг даатгалд хамрагдах зорилгоор зарцуулж болно. Монголын МСС (эсхүл, МСК-аас урьдчилан зөвшөөрсөн өөр бусад этгээд)-ийг даатгалын төлбөрийг төлөгч хийгээд нөхөн төлбөр, эсхүл гүйцэтгэлийн баталгааг хүлээн авагчаар заана. Даатгалын аливаа гэрээнд Монголын МСС-г үндсэн даатгуулагчаар нэрлээгүй тохиолдолд нэмэлт даатгуулагчаар (МСК-аас хүссэн тохиолдолд МСК-ийг мөн) оруулсан байна. Засгийн газар нь даатгал, баталгааны дагуу төлсөн нөхөн төлбөрийн талаар МСК-д шуурхай мэдэгдэх бөгөөд тэрхүү нөхөн төлбөрийг Монголын МСС-аас заасан Зөвшөөрөгдсөн данс руу шилжүүлсэн, эсхүл МСК-аас заасан өөр бусад хэлбэрээр шилжүүлэн авсан тохиолдолд Засгийн газар нь тухайн гэмтсэн эсхүл алдагдсан Хөтөлбөрийн хөрөнгийг шинээр орлуулах, засварлахад зарцуулах бүхий л арга хэмжээг авна.

(viii) Монголын МСС-д нөхөн төлбөр ногдуулах. Монголын МСС-д нөхөн төлбөр ногдуулсан, эсхүл аливаа гэрээний дагуу өөр бусад ижил төстэй хариуцлага ногдуулсан тохиолдолд Засгийн газар нь Монголын МСС-ийн нэрийн өмнөөс тухайн нөхөн төлбөрийг бүрэн төлж барагдуулах ба ингэхдээ МСК-ийн санхүүжилт, Засгийн газрын оруулах хувь хэмжээ, эсхүл Хөтөлбөрийн өмч хөрөнгийг ашиглахыг хориглоно. Түүнчлэн, Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, Ажиглагч гишүүн, Оролцогч талуудын хорооны гишүүн, Монголын МСС-ийн Үндсэн болон бусад ажилтан тус бүрийг Монголын МСС-ийн нэрийн өмнөөс үүргээ гүйцэтгэх явцад гарсан аливаа нэхэмжлэл, зардал, хохирол, зарлагыг, тухайн хүний ноцтой хайнга байдал, ухамсартайгаар үйлдсэн буруутай үйл ажиллагаа, залилан зэргээс бусад тохиолдолд, төлж барагдуулан, хохиролгүй болгох бөгөөд Засгийн газар нь энэхүү 1.3(b)(viii) дахь хэсэгт заасан үүргээ биелүүлэхдээ МСК-ийн санхүүжилт, Засгийн газрын оруулах хувь хэмжээ, эсхүл Хөтөлбөрийн өмч хөрөнгийг ашиглахыг мөн хориглоно.

2 ДУГААР ЗҮЙЛ ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭ

2.1 Хэсэг Хэрэгжилтийн төлөвлөгөө.

Талууд Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээг агуулга болон хэлбэрийн хувьд МСК-аас танилцан баталсан дараах багц бичиг баримтуудад лавшруулан заахаар тохиролцов. Үүнд: (i) Ажлын төлөвлөгөө, (ii) Санхүүгийн нарийвчилсан төлөвлөгөө, (iii) Аудитын төлөвлөгөө, (iv) Худалдан авалтын төлөвлөгөө (тус бүрт нь **“Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичиг”**, хамтад нь **“Хэрэгжилтийн төлөвлөгөө”** гэх) зэрэг болно. Монголын МСС нь Хөтөлбөрийн санхүүжилтийн анхны Зарцуулалтыг гүйцэтгэхээс өмнө, улмаар дор хаяж жил тутам (эсхүл, Хөтөлбөрийн зааварчилгаанд заасан өөр бусад давтамжаар), өөрийн санал болгож буй Хэрэгжилтийн төлөвлөгөөг МСК-д хүргүүлж, хянуулан батлуулна. Монголын МСС-аас санал болгосон Хэрэгжилтийн төлөвлөгөөг МСК хянаж, шаардлагатай

тохиолдолд нэмэлт тодруулга авах, эсхүл холбогдох өөрчлөлт хийх хүсэлтийг Монголын МСС-д тавина. Монголын МСС нь Хөтөлбөрт томоохон өөрчлөлт орсон, эсхүл тухайн жилд хүрэх үр дүн, зорилтууд, гүйцэтгэх ажлыг цаг тухайд нь биелүүлэх боломжгүй болсон хэмээн үзсэн тохиолдолд Монголын МСС нь жилийн аль улирал байхаас үл хамааран шинэчлэгдсэн Хэрэгжилтийн төлөвлөгөө, эсхүл Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичгийг МСК-д хүргүүлэх бөгөөд ингэхдээ шинэчилсэн Санхүүгийн нарийвчилсан төлөвлөгөөг улирал бүр мөн хүргүүлнэ. Ийм тохиолдолд Монголын МСС нь шинэчилсэн Хэрэгжилтийн төлөвлөгөө, эсхүл Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичгийг дараагийн Хуваарьт тайлантай нэг өдөр хүргүүлнэ. Монголын МСС нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Хэрэгжилтийн төлөвлөгөөнд нийцүүлнэ.

(a) Ажлын төлөвлөгөө. Монголын МСС нь Хөтөлбөрийг удирдан зохион байгуулахдаа агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ ("**Ажлын төлөвлөгөө**" гэх). Түүнчлэн Засгийн газар нь МСК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Төсөл болон/эсхүл Үйл ажиллагаатай холбоотой бусад ажлын төлөвлөгөөг тухай бүр боловсруулан баталж, мөрдөж ажиллана.

(b) Санхүүгийн нарийвчилсан төлөвлөгөө. Компакт гэрээний II Хавсралт буюу Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацааны санхүүгийн төлөвлөгөөний хураангуйд Хөтөлбөрийг удирдан зохион байгуулах, мониторинг, үнэлгээ хийхэд болон Төслийг хэрэгжүүлэхэд жил тутам зарцуулах МСК-ийн санхүүжилт болон Засгийн газрын оруулах хувь хэмжээг харуулсан ("**Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацааны санхүүгийн төлөвлөгөө**" гэх). МСК-аас бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Монголын МСС нь тухайн жилийн дараагийн жилийн улирал тутам, улмаар Компакт гэрээ хэрэгжих үлдсэн хугацаа болон Хаалтын хугацааны жил бүрээр Тайлан гаргах зааварчилгаанд заасны дагуу санхүүгийн нарийвчилсан төлөвлөгөөг Хөтөлбөр (захиргааны зардлыг оролцуулан) болон Төсөл, түүний дэд үйл ажиллагааны түвшинд (шаардлагатай тохиолдолд илүү нарийвчилсан түвшинд) задлан, төсөвлөгдсөн болон тухай бүр шаардлагатай мөнгөн хөрөнгөд суурилсан аль аль хэлбэрээр боловсруулж, хэрэгжүүлнэ.

(c) Аудитын төлөвлөгөө. Монголын МСС нь Аудитын зааварчилгаанд заасны дагуу аудитад хамрагдах шаардлага бүхий байгууллагуудын зарцуулалтыг хянах аудитын төлөвлөгөө ("**Аудитын Төлөвлөгөө**" гэх)-г боловсруулж, хэрэгжүүлнэ. Аудитын төлөвлөгөөг агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн, аудитын эхний хугацаа дуусахаас дор хаяж 60 (жар) хоногийн өмнө боловсруулсан байна.

(d) Худалдан авалтын төлөвлөгөө. Монголын МСС нь Компакт гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа материал, ажил, зөвлөх болон бусад үйлчилгээг худалдан авах төлөвлөгөө (тус бүрийг "**Худалдан авалтын төлөвлөгөө**" гэх)-г улирал бүрээр боловсруулна. Худалдан авалтын төлөвлөгөө тус бүрийг МСК-ийн Хөтөлбөрийн худалдан авалтын зааварчилгааны дагуу боловсруулж, тухай бүр шинэчилж явна. Түүнчлэн, Монголын МСС нь Компакт гэрээнд гарын үсэг зурснаас хойш зургаан сараас илүүгүй хугацаанд багтан нийлүүлэгч, гэрээлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч зэрэг сонирхогч талуудад худалдан авалтын үйл ажиллагаа болон шийдвэртэй танилцах, хянуулах боломж олгосон санал, гомдол хүлээн авч, шийдвэрлэх журам ("**Санал, гомдол хүлээн**

авч, шийдвэрлэх журам” гэх)-ыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Уг журмын бүтэц, агуулга, дүрэм, үйл явцыг МСК-аас батлах ба МСК-аас ийнхүү баталсан журмыг Монголын МСС өөрийн цахим хуудаст байршуулна.

2.2 Хэсэг Санхүүгийн Хариуцлагын Төлөвлөгөө.

МСК-аас бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Монголын МСС нь МСК-ийн санхүүжилт, эсхүл Засгийн газрын оруулах хувь хэмжээг зарцуулах, тухайлбал, буцалтгүй тусламжийн хөрөнгийг зарцуулах, эсхүл хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх болон бараа материал, ажил үйлчилгээ худалдан авахдаа нээлттэй, шударга, өрсөлдөөний зарчмыг ил тод баримталсан байдлаар гүйцэтгэх нөхцөлийг хангасан зааварчилгааг боловсруулж, хэрэгжүүлнэ (**“Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө”** гэх). Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө нь (a) төсөв, (b) нягтлан-бодох бүртгэл, (c) мөнгөн хөрөнгийн удирдлага, (d) санхүүгийн гүйлгээ (нэхэмжлэх ба төлбөр), (e) Зөвшөөрөгдсөн данс нээх, тэдгээрийг удирдах, (f) албан хаагчид болон цалин, (g) томилолт болон тээврийн хэрэгслийн ашиглалт, (h) хөрөнгө, түүний бүртгэл, (i) аудит, (j) тайлагнах болон бусад асуудлаарх шаардлагуудыг агуулсан байна. Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөнд МСК-ийн хянаж, зөвшөөрсний дагуу тухай бүр өөрчлөлт оруулж болно.

2.3 Хэсэг Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө.

МСК-аас бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Монголын МСС нь Компакт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 90 (ер) хоногийн дотор Компакт гэрээ хэрэгжих хугацаанд Хөтөлбөрийн мониторинг, үнэлгээний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үндсэн баримт бичиг болох Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ. Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг МСК-ийн *Компакт гэрээ болон Эрх бүхий орноор шалгарах бэлтгэл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх Мониторинг, үнэлгээний бодлогын* дагуу боловсруулан хэрэгжүүлж, тухай бүр шинэчилнэ.

2.4 Хэсэг Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн төлөвлөгөө.

Энэхүү Гэрээний 1.2(b)(iii) дахь хэсэгт заасны дагуу Монголын МСС нь МСК-ийн хөрөнгө, эсхүл Засгийн газрын оруулах хувь хэмжээнээс хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь (шууд эсхүл шууд бусаар) санхүүжүүлсэн үйл ажиллагаануудыг МСК-ийн *Байгаль орчны зааварчилгаа*, түүний дотор энд жишиг болгон оруулсан ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартуудад нийцүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна. Тодруулбал, Монголын МСС нь (i) Компакт гэрээний хүрээнд хэрэгжих бүх Үйл ажиллагааг хамарсан Байгаль орчин, нийгмийн менежментийн системийг боловсруулж, батална, (ii) тухайн үед хийгдэж буй Байгаль орчин, нийгмийн байдалд үзүүлэх нөлөөллийн аливаа үнэлгээний ажлыг гүйцээх, эсхүл тэрхүү ажилтай үйл ажиллагаа уялдуулах, хамтрах, улмаар шаардлагатай тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, МСК-ийн *Байгаль орчны зааварчилгаа*, энэхүү Гэрээ, Компакт гэрээ, холбогдох бусад Нэмэлт гэрээ, Хөтөлбөрийн зааварчилгаагаар, эсхүл МСК-аас тухай бүр шаардлага болгосны дагуу байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нэмэлт үнэлгээ, шинжилгээ, тухайлбал, Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, байгаль орчин, нийгмийн аудит, Нүүлгэн суурьшуулалтын бодлогын бичиг баримт, Нүүлгэн суурьшуулалтын үйл

ажиллагааны төлөвлөгөө зэргийг тус бүр агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ, (iii) аливаа Төсөл, эсхүл Үйл ажиллагаанд зориулж тусгайлан боловсруулсан Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах ба ингэхдээ түүнд тусгасан бүх төрлийн арга хэмжээг төслийн бүтэц, агуулга, худалдан авах ажиллагааны холбогдох баримт бичиг, бусад дагалдах гэрээ тус бүрт агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлага хангахуйц байдлаар уялдуулан тусгана, (iv) Компакт гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн байгаль орчин, нийгмийн аливаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор, эсхүл өмнө дурдсан үнэлгээ, төлөвлөгөөнд туссан байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг саармагжуулах зохих арга хэмжээг тодорхойлж, МСК-ийн шаардлага хангахуйц байдлаар хэрэгжүүлнэ.

2.5 Хэсэг Нийгэм, жендэрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах төлөвлөгөө.

Энэхүү Гэрээний 1.2(b)(iv) дэх хэсэгт заасны дагуу Монголын МСС нь нийгэм, жендэрийн асуудлыг Төсөл болон Үйл ажиллагааны нийт цар хүрээнд авч үзэх бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд мөн анхаарал хандуулахын зэрэгцээ МСК-ийн *Жендэрийн бодлого* болон *Жендэрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах зааварчилгааг* сахин мөрдөх нөхцөлийг хангана. Тодруулбал, Монголын МСС нь нийгэм, жендэрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд хэрхэн тусгах талаар цогц төлөвлөгөө боловсруулах бөгөөд ингэхдээ дор хаяж дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: (i) эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн болон/эсхүл цөөнхийн бусад бүлэгтэй тогтмол давтамжтайгаар, тэгш оролцоог хангасан, ач холбогдолтой байдлаар зөвлөлдөх ажиллагааны аргачлалыг тогтоосон байх; (ii) тухайн Төсөлтэй холбогдуулан гүйцэтгэсэн нийгэм, жендэрийн судалгааны үр дүн, зөвлөмжийг тухайн Төслийн бүтэц, агуулгад хэрхэн тусгах стратегийг боловсруулсан байх; (iii) Компакт гэрээ хэрэгжих хугацаанд тухайн Төслийн хүрээнд дэвшүүлсэн нийгмийн тэгш оролцоо, жендэрийн тэгш байдлыг хангах зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн тухайлсан арга хэмжээг тодорхойлсон байх; (iv) тэдгээр арга хэмжээтэй холбогдон үүсэх үүрэг хариуцлага, цаг хугацааны төлөвлөгөө болон тэдгээрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн зэргийг тодорхойлсон байх; (v) Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацаанд уялдаа холбоог хангаж, мониторинг хийх нөхцөлийг хангасан байх; (vi) авч хэрэгжүүлэх Үйл ажиллагааны бүтэц, агуулга, барилга, угсралтын ажлын тендерийн баримт бичиг, хэрэгжилтийн төлөвлөгөө зэргийг нийгэм, жендэрийн дүн шинжилгээний үр дүнтэй нийцүүлсэн, тэдгээрийг тусгасан байх зэрэг болно. Монголын МСС нь Нийгэм, жендэрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах төлөвлөгөөг жил бүр хянан үзэж, шаардлагатай тохиолдолд тухайн Төслийн хүрээнд гүйцэтгэсэн судалгаа шинжилгээний үр дүн, шинэ тутам хуримтлуулсан туршлагад тулгуурлан шинэчилнэ.

2.6 Хэсэг МСК-ийн Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа, Буцалтгүй тусламж олгох МСК-ийн зөвшөөрөл.

Компакт гэрээний 3.6 дахь хэсэгт заасны дагуу:

(a) Монголын МСС нь Компакт гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа (болон тендер)-г зохион байгуулах, худалдан авалтын гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг удирдан

зохион байгуулахдаа МСК-ийн Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгааг дагаж мөрдөнө. Түүнчлэн Засгийн газар нь худалдан авах ажиллагаатай холбоотой аливаа санал, гомдлыг авч хэлэлцэх, барагдуулах ажиллагаа нь МСК-ийн Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа болон Санал, гомдол хүлээн авч, шийдвэрлэх журамд нийцсэн байх нөхцөлийг хангана;

(b) МСК бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Монголын МСС нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын бус аливаа байгууллагад буцалтгүй тусламж олгох, ийнхүү олгох ажиллагааг удирдан зохион байгуулахдаа нээлттэй, шударга, өрсөлдөөний зарчмыг ил тод баримталсан байдлаар гүйцэтгэнэ.

2.7 Хэсэг Нийлүүлэгчдэд хүргэх мэдэгдэл; Компакт гэрээний зарим зүйл заалтыг түүнд тусгах.

Монголын МСС нь Компакт гэрээний 2.7 дахь хэсэг, мөн 3.8 дахь хэсгийн (b), (c), (d) дэх заалтуудад тус тус дурдсан шаардлагуудын талаар нийт Нийлүүлэгчид (болон Хөтөлбөртэй холбоотойгоор МСК-ийн санхүүжилт, эсхүл Засгийн газрын оруулах хувь хэмжээний хөрөнгөөс хүлээн авч буй бүх хуулийн этгээд, хувь хүмүүс)-д мэдэгдэх бөгөөд МСК нь Нийлүүлэгчтэй хийх аливаа гэрээний нэг тал биш тохиолдолд тэдгээр гэрээнд эдгээр шаардлагыг заан оруулсан байх нөхцөлийг хангана.

2.8 Хэсэг Тайлан; Мэдэгдэл.

(a) МСК-аас бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Монголын МСС нь Тайлан гаргах зааварчилгаанд заасан тайлан, мэдээлэл (тус бүрийг **“Хуваарьт тайлан”** гэх)-ийг агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, товлосон хугацаанд МСК-д хүргүүлнэ. Монголын МСС нь МСК-д Хуваарьт тайланг хүргүүлэхдээ Тайлан гаргах зааварчилгаанд заасан хугацааг баримтлах бөгөөд Тайлан гаргах зааварчилгаанд бүх талаар нийцүүлсэн байна.

(b) Монголын МСС нь Компакт гэрээ хэрэгжих хугацааны турш жил бүрийн 10 дугаар сарын 30-ны өдөр (эсхүл МСК-аас бичгээр хүсэлт ирүүлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор) дараах мэдээллийг агуулсан, тухайн жилийн нэмэлт тайланг МСК-д хүргүүлнэ. Үүнд:

(i) Компакт гэрээний зорилго, Төслийн зорилтод хүрэх чиглэлээр Засгийн газраас хийж гүйцэтгэсэн ажлын явц, гаргасан ахиц дэвшил;

(ii) Хуваарьт тайланд тусаагүй бусад ололт, ахицын талаарх нэмэлт мэдээлэл;

(iii) Компакт гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч хэрэгжүүлж буй зөвлөлдөх ажиллагаа, хандивлагч байгууллагууд хоорондын уялдаа холбоо, хуримтлуулсан туршлага, сургамж;

(iv) МСК-ийн Байгаль орчны зааварчилгаа (болон түүнд жишиг болгон оруулсан ОУСК-ийн үйл ажиллагааны стандартыг оролцуулан), Аудитын аливаа төлөвлөгөө, эсхүл Хэрэгжилтийн төлөвлөгөөний бусад баримт бичгүүд зэрэг орно.

(c) Компакт гэрээ хэрэгжих хугацаанд, Засгийн газар нь улсын нэгдсэн төсөвт, эсхүл Засгийн газрын эрх бүхий аливаа байгууллага нь тухайн яам, агентлаг, хот, бүс нутаг, эсхүл засаг захиргааны өөр бусад түвшний төсөвт МСК-ийн

санхүүжилтээс бусад эх үүсвэрээс төсөвлөсөн болон хүлээн авахаар төлөвлөж буй хөрөнгө, санхүүжилтийг өөр зориулалтаар дахин хуваарилсан, хуваарилагдсан хөрөнгийн хэмжээг бууруулсан, эсхүл Компакт гэрээ болон Хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаанд зориулан төсөвлөсөн хөрөнгийг цаг тухайд нь хуваарилаагүй тохиолдолд Засгийн газар нь тухайн хөрөнгийг ийнхүү дахин хуваарилсан, хэмжээг бууруулсан, цаг тухайд нь хуваарилаагүй өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор Монголын МСС-аар дамжуулан МСК-д мэдэгдэх бөгөөд тэрхүү мэдэгдэлд дахин хуваарилсан, бууруулсан, эсхүл цаг тухайд нь хуваарилаагүй хөрөнгийн хэмжээ, ингэснээр аль Үйл ажиллагаанд нөлөөлж байгаа, ийнхүү дахин хуваарилах, хэмжээг бууруулах үндэслэл зэргийн талаар тайлбарласан байна.

(d) Монголын МСС нь Хуваарьт тайлангаас гадна МСК-аар бичгээр хүсэлт ирүүлснээс хойш гуч (30) хоногийн дотор, эсхүл МСК-тай өөрөөр харилцан зөвшөөрснөөс бусад тохиолдолд, ийнхүү хүссэн, эсхүл зөвшөөрсөн Хөтөлбөр, түүний хэрэгжилт, хяналт, үнэлгээтэй холбоотой тайлан, баримт бичиг, мэдээллийг тухай бүрт хүргүүлнэ.

(e) Монголын МСС нь Хуваарьт тайлан болон МСК-аас хүссэн аливаа бусад тайлан, баримт бичгийг цахим хэлбэрээр, эсхүл Тайлан гаргах зааварчилгаанд заасан өөр бусад хэлбэрээр хүргүүлнэ.

(f) Монголын МСС нь Төслийн зорилтыг биелүүлэх хүрээнд Засгийн газрын оруулж буй хувь хэмжээ ямар үүрэг гүйцэтгэж буй талаарх тайланг агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, хүргүүлнэ. Уг тайланд өнгөрөгч 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болон дууссан оны мэдээлэл, түүнчлэн дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болох жилд оруулах Засгийн газрын хувь хэмжээний талаарх мэдээллийг тус тус оруулах бөгөөд Талууд бичгээр өөрөөр тохироогүй бол МСК-д тухайн оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хэтрэлгүй хүргүүлнэ.

2.9 Хэсэг МСК-аас зөвшөөрөл авах шаардлагатай гүйлгээ.

Дараах гүйлгээ, үйл ажиллагааг гүйцэтгэх, гэрээ, баримт бичгийг гаргахын өмнө МСК-аас бичгээр тус тус зөвшөөрөл авсан байна. Үүнд:

- (a) Санхүүжилтийн Зарцуулалт;
- (b) Хэрэгжилтийн төлөвлөгөө (Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичиг тус бүр), Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө, Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө болон эдгээрт орсон аливаа өөрчлөлт;
- (c) Засгийн газар болон Монголын МСС-ийн хооронд байгуулсан аливаа гэрээ болон дор дурдсан аливаа этгээдийг томилсон, хөлсөлсөн, эсхүл өөр бусад байдлаар хамтран ажиллахаар тохирсон гэрээ (тус бүр “**Үндсэн гэрээ**” гэх):
 - (i) Аудитор, эсхүл Хянан шалгагч;
 - (ii) Санхүүгийн агент;
 - (iii) Худалдан авах ажиллагааны төлөөлөгч;
 - (iv) Банк;
 - (v) Хэрэгжүүлэгч байгууллага;
 - (vi) Төслийн хөндлөнгийн менежер;
 - (vii) Удирдах зөвлөлийн гишүүн болон Ажиглагч гишүүн, Монголын МСС-ийн Үндсэн ажилтан (болон тэдгээрт олгох нөхөн төлбөрийн

талаарх аливаа гэрээ);

(d) Үндсэн гэрээнд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, үйлчлэлийг түр зогсоох, эсхүл эдгээртэй дүйцэхүйц үр дагавар бүхий аливаа үйлдэл;

(e) Монголын МСС болон МСС-аас хамаарал бүхий этгээдийн хооронд байгуулж буй гэрээ, эсхүл хийж буй гүйлгээ;

(f) МСК-ийн аливаа санхүүжилт, Засгийн газрын оруулах хувь хэмжээ, Хөтөлбөрийн өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр барьцаалах, эсхүл шууд болон шууд бус байдлаар өр зээл үүсгэсэн, баталгаа гаргах;

(g) Монголын МСС-г үүсгэн байгуулах, зохион байгуулах, удирдах талаар шийдвэрлэсэн, зохицуулсан (төрийн бүх байгууллагад нийтлэг үйлчилдэг хууль тогтоомжоос бусад), эсхүл тэдгээр үйл ажиллагаатай холбогдуулан гаргаж буй аливаа зарлиг, хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээний аливаа зохицуулалт, эсхүл өөр бусад баримт бичиг (дотоод журам, Хүний нөөцийн зааварчилгаа болон боловсон хүчний аливаа төлөвлөгөө зэргийг оролцуулан) (тус бүр **“Үндсэн баримт бичиг”** гэх);

(h) Монголын МСС-г бүхэлд нь буюу хэсэгчлэн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, цомхтгох, бүтцийн өөрчлөлт хийх, эсхүл Монголын МСС-д өөр бусад аливаа өөрчлөлт орох нөхцөл байдал үүсэх;

(i) Зөвшөөрөгдсөн дансны байршил, нөхцөл байдалд гарсан аливаа өөрчлөлт;

(j) (i) Удирдах зөвлөлийн гишүүн, эсхүл Ажиглагч гишүүн, Удирдах зөвлөлийн дарга, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн тоонд өөрчлөлт орох, Удирдах зөвлөлийн гишүүн эсхүл Ажиглагч гишүүний аливаа сул орон тоог нөхөх, (ii) Монголын МСС-ийн Үндсэн ажилтнууд, эсхүл Удирдлагын багийн хэмжээ, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох, тэдгээрт гарсан сул орон тоог нөхөх (Үндсэн ажилтныг сонгон шалгаруулах, ажилд авахтай холбоотой аливаа үйл ажиллагааг оролцуулан), (iii) Оролцогч талуудын аливаа хорооны хэмжээ, бүрэлдэхүүнд орсон зарчмын шинжтэй аливаа өөрчлөлт;

(k) Монголын МСС Компакт гэрээ хэрэгжих хугацаанд МСК-ийн санхүүжилтээс гадна бусад эх үүсвэрээс (Улсын төсвөөс, эсхүл аливаа хандивлагч байгууллагын эх үүсвэрийг оролцуулан) аливаа хөрөнгийг татан төвлөрүүлэх, хүлээн авах, гүйцэтгэлийг удирдан зохион байгуулах, эсхүл Оноосон эрх, үүргээс бусад аливаа үйл ажиллагаанд оролцох, үүрэг хариуцлага гүйцэтгэх шийдвэр гаргах;

(l) МСК-аас зөвшөөрөл авах шаардлагатай гэж Хөтөлбөрийн зааварчилгаанд тусгасан аливаа гэрээ, гүйлгээ, шийдвэр, эсхүл өөр бусад арга хэмжээ, баримт бичиг;

(m) Дээр дурдсан аливаа баримт бичиг, зохицуулалтад аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах, тэдгээрийг орлуулан солих, дуусгавар болгох, хүчингүй болгох, эсхүл өөр бусад аливаа өөрчлөлтүүд зэрэг хамаарна.

2.10 Хэсэг Зарим тодорхой этгээдийн Хэрэгжилтэд гүйцэтгэх үүрэг

(a) Төслийн хөндлөнгийн менежер. Монголын МСС нь Төсөл, Үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг зохих ёсоор, үр ашигтайгаар гүйцэтгэхэд тохиромжтой хэмээн үзсэн, түүнчлэн МСК-ийн Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаанд ийнхүү заасан тохиолдолд мэргэжлийн

шаардлага хангасан хувь хүн, эсхүл байгууллагыг Төслийн хөндлөнгийн менежерээр авч ажиллуулах эрхтэй (тус бүр **“Төслийн хөндлөнгийн менежер”** гэх) бөгөөд ингэхдээ Төслийн хөндлөнгийн менежерийг томилох, эсхүл хамтран ажиллахдаа өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын зарчмыг баримталж, МСК-ийн Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаанд заасан тохиолдолд томилох, эсхүл хамтран ажиллахын өмнө Удирдах зөвлөл болон МСК-аас зөвшөөрөл авна. Ийнхүү зөвшөөрөл авсны дараа Монголын МСС Төслийн хөндлөнгийн менежерт Хэрэгжүүлэгч байгууллага, эсхүл Төсөл, Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалттай холбогдуулан шаардлагатай гэж үзсэн үүрэг, хариуцлагыг шилжүүлж, оноож, гэрээгээр олгож болно. Гэхдээ үүрэг хариуцлагыг ийнхүү шилжүүлсэн, оноосон, гэрээгээр олгосон гэдгээс үл хамааран Монголын МСС нь эдгээр үүрэг, хариуцлага болон Төслийн хөндлөнгийн менежерээс ирүүлсэн аливаа тайлангийн өмнөөс эцсийн хариуцлагыг хүлээх бөгөөд Төслийн хөндлөнгийн менежерийн үйл ажиллагаанд Санхүүгийн төлөөлөгч болон Худалдан авах ажиллагааны төлөөлөгч хяналт тавина. Удирдах зөвлөл нэг буюу түүнээс дээш тооны Төслийн хөндлөнгийн менежертэй байх нь оновчтой хэмээн үзвэл Монголын МСС, улмаар шаардлагатай тохиолдолд Худалдан авах ажиллагааны төлөөлөгчид тэдгээр Төслийн хөндлөнгийн менежерийг сонгох өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын ажиллагааг эхлүүлэх зааврыг өгч болно.

(b) Санхүүгийн төлөөлөгч. Монголын МСС нь дараах үүргийг гүйцэтгэх Санхүүгийн төлөөлөгчтэй байна. Үүнд: (i) Санхүүгийн төлөөлөгчтэй байгуулсан гэрээ болон Банктай байгуулсан хүчин төгөлдөр гэрээнд заасны дагуу Зарцуулалтуудад зохих ёсоор зөвшөөрөл авсан, баримтжуулсан эсэхэд хяналт тавих, баталгаажуулах, (ii) Зөвшөөрөгдсөн данснаас Зарцуулалт хийх зааварчилгааг Банкинд өгөх, эсхүл Төлбөрийн нэгдсэн систем, эсхүл МСК-аас баталсан төлбөрийн өөр бусад аливаа системийн дагуу, тухай бүр Санхүүгийн төлөөлөгчөөс холбогдох баталгаажуулалтыг хийсний дараа, тухайн бараа, материал, ажил, үйлчилгээний төлбөрийг нийлүүлэгчид шууд шилжүүлэх хүсэлт гаргах, (iii) Зарцуулалтын бүх хүсэлтийг зохих ёсоор баталгаажуулах, (iv) МСК-ийн санхүүжилт болон Засгийн газрын оруулах хувь хэмжээтэй холбоотой хийсэн санхүүгийн бүх гүйлгээний нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх, (v) Санхүүгийн төлөөлөгчтэй байгуулсан гэрээ, эсхүл Банктай байгуулсан хүчин төгөлдөр гэрээнд заасан журмын дагуу Зарцуулалтын тайланг боловсруулах зэрэг орно. Монголын МСС нь Санхүүгийн төлөөлөгчтэй агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан гэрээ байгуулж ажиллах ба **“Санхүүгийн төлөөлөгчийн гэрээ”** гэх) уг гэрээнд Санхүүгийн төлөөлөгчийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага болон холбогдох бусад нөхцөл, шаардлагуудыг тусгана. МСК бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Санхүүгийн төлөөлөгч нь Засгийн газраас хараат бус, хөндлөнгийн этгээд байна.

(c) Аудитор, хянан шалгагчид. Монголын МСС нь Аудитын зааварчилгаанд заасны дагуу нэг буюу түүнээс дээш тооны аудитортой хамтран ажиллана (тус бүр **“Аудитор”** гэх). МСК-аас тухай бүр бичгээр хүсэлт ирүүлсний дагуу Монголын МСС нь мөн (i) Компакт гэрээний хэрэгжилт болон гүйцэтгэлд хяналт тавих чиглэлээр (А) хэрэгжилт болон гүйцэтгэлд ерөнхий үнэлгээ хийх, (B) байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлд аудит хийх, (C) Компакт гэрээний III Хавсралтад дэлгэрэнгүй заасан Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний дагуу мэдээллийн чанарын үнэлгээг

гүйцэтгэх эрх бүхий хараат бус хянагч шалгагчтай байх болон/эсхүл (ii) Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний мэргэжилтэнтэй байж болно (тус бүр **“Хянан шалгагч”** гэх). Монголын МСС нь Аудитор болон/эсхүл Хянан шалгалгчийг сонгохдоо Аудитын зааварчилгаа болон Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг баримтална. Монголын МСС нь Аудитор, Хянан шалгагчтай агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан гэрээ байгуулж ажиллах ба тэрхүү гэрээнд аудит, хяналт шалгалт, үнэлгээг гүйцэтгэхтэй холбогдуулан Аудитор, эсхүл Хянан шалгагчийн хүлээх үүрэг, хариуцлага, түүний дотор баримт бичиг, мэдээлэл, барилга, байгууламж, талбарт нэвтрэх эрх, аудит, хяналт шалгалт, үнэлгээний агуулга, хэлбэрт тавигдах шаардлага, холбогдох бусад нөхцөл, шаардлагуудыг оруулна (**“Аудитор/Хянан шалгагчийн гэрээ”** гэх).

(d) Худалдан авах ажиллагааны төлөөлөгч. Монголын МСС нь Компакт гэрээ болон энэхүү Гэрээний хэрэгжилтийг хангахтай холбогдуулан худалдан авах үйл ажиллагааг гүйцэтгэх болон/эсхүл баталгаажуулах үүрэг бүхий Худалдан авах ажиллагааны төлөөлөгчтэй байна. Монголын МСС нь Худалдан авах ажиллагааны төлөөлөгчтэй агуулга болон хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан гэрээ байгуулж ажиллах ба (**“Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн гэрээ”** гэх) уг гэрээнд худалдан авах ажиллагааг гүйцэтгэх, хяналт тавих, шалгахтай холбоотойгоор Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага болон холбогдох бусад нөхцөл, шаардлагуудыг тусгана. МСК бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Худалдан авах ажиллагааны төлөөлөгч нь Засгийн газраас хараат бус, хөндлөнгийн этгээд байна.

2.11 Хэсэг Олон нийтэд хүргэх мэдээлэл, Ил тод байдал

(a) Энэхүү Гэрээний 2.12 дахь хэсэгт заасны дагуу Монголын МСС нь Компакт гэрээ нь МСК-аар дамжуулан АНУ-ын хувь нэмэр оруулсан хөтөлбөр болох талаар олон нийтэд зохих байдлаар мэдээлэх үйл ажиллагааг явуулах бөгөөд ингэхдээ Хөтөлбөрийн Үйл ажиллагааг хэрэгжүүлэх байршлуудыг зааж, Хөтөлбөрийн өмч хөрөнгийг бүхэлд нь МСК-ийн *Тэмдэг, тэмдэглэгээний олон улсын стандартад* нийцүүлэн тэмдэгжүүлнэ. Компакт гэрээг хүчингүй болгосон тохиолдолд, эсхүл дуусгавар болсны дараа, МСК-аас хүсэлт гаргасны дагуу, Засгийн газар нь Монголын МСС-ийн цахим хуудас, эсхүл Засгийн газар, Монголын МСС-аас олон нийтэд хандан гаргасан аливаа мэдээлэл, материалаас эдгээр тэмдэг, тэмдэглэгээг арилгана.

(b) Монголын МСС нь *Засаглалын зааварчилгаанд* заасны дагуу Компакт гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх бөгөөд ингэхдээ дараах баримт бичгийг англи хэл дээр Монголын МСС-ийн цахим хуудас (**“Монголын МСС-ийн цахим хуудас”** гэх)-д байрлуулах зэрэг арга хэмжээг авна. Үүнд: (i) Компакт гэрээ, (ii) энэхүү Гэрээ, (iii) Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл болон Монголын МСС-тай холбоотой Оролцогч талуудын хорооны хурлын тэмдэглэл; (iv) Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө болон Хөтөлбөрийн гүйцэтгэлийн талаарх Хуваарьт тайлан, Эцсийн тайлан; (v) Төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлан, нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааны төлөвлөгөө болон холбогдох бусад баримт бичгүүд; (vi) нийгэм, жендэрийн бүх үнэлгээ болон Нийгэм, жендерийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд

тусгах төлөвлөгөө; (vii) Аудиторын боловсруулсан аудитын бүх тайлан болон Хянан шалгагчийн боловсруулсан хуваарьт тайлан, гүйцэтгэсэн үнэлгээ; (viii) Зарцуулалтын бүх хүсэлт; (ix) энэхүү Гэрээний дагуу МСК-д хүргүүлэх ёстой бүх тайлан (энэхүү Гэрээний 2.8(a) дахь хэсгийн дагуу шаардлага болгосон бүх тайланг оролцуулан); (x) худалдан авах ажиллагаатай холбоотой бүх бодлого, дүрэм, журам (жишиг баримт бичгүүд, худалдан авалтын төлөвлөгөө, байгуулсан гэрээнүүд болон санал, гомдол хүлээн авч, шийдвэрлэх журам зэргийг оролцуулан) болон МСК-ийн Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаанд олон нийтэд нээлттэй байлгах аар заасан худалдан авах ажиллагааны өөр бусад баримт бичгүүд; (xi) Монголын МСС-г үүсгэн байгуулсан болон Монголын МСС-ийн засаглал, бүтэц, зохион байгуулалттай холбоотой аливаа хууль тогтоомж болон холбогдох бусад баримт бичгийн хувь (нууцын ангилалд багтсанаас бусад), түүний дотор Засаглалын баримт бичиг болон тэдгээрт орсон аливаа нэмэлт өөрчлөлт; (xii) МСК-аас хүссэн бусад материал зэрэг багтах бөгөөд ингэхдээ МСК-тай холбоотой аливаа хэвлэлийн мэдээ, мэдэгдэл, эсхүл МСК нь Хөтөлбөрийг санхүүжүүлж буй талаар, эсхүл МСК-ийг ишлэл болгон дурдсан хэвлэлийн аливаа мэдээ, мэдээллийг гаргахын өмнө МСК-аас урьдчилан зөвшөөрөл авах ба холбогдох Хэрэгжүүлэх захидалд МСК-аас заан ирүүлсэн аливаа заавартай нийцүүлсэн байна.

(c) энэхүү Гэрээний 2.11(b) дэх хэсгээс үл хамааран, гэрээ байгуулах эрх олгохоос өмнөх хугацаанд хамаарах худалдан авалтын үйл ажиллагааны тухай мэдээлэл, Монголын МСС-ийн ажилтан, гүйцэтгэгч, зөвлөхүүдтэй байгуулсан гэрээтэй холбоотой нууц мэдээллийг олон нийтэд ил болгохгүй бөгөөд ингэхдээ МСК болон Монголын МСС нь олон нийтэд ил болгохгүй аливаа мэдээлэл нь нууцад хамаарах эсэх талаар харилцан тогтоосон байна.

2.12 Хэсэг Брэнд, Брэндийг ашиглах.

(a) Энэхүү Гэрээний 4.2(g) дэх хэсэгт заасны дагуу МСК нь МСК-ийн лого болон “Мянганы сорилтын корпораци,” “Мянганы сорилтын сан,” “МСК” гэсэн нэрс тус бүрийг зөвхөн МСК-ийн *Тэмдэг, тэмдэглэгээний олон улсын стандартад* нийцүүлэн ашиглах эрх, лицензийг эргэлт буцалтгүй, үнэ төлбөргүй, дамжуулан ашиглах боломжтой байдлаар Монголын МСС-д олгов. Лого болон нэрийг ийнхүү ашиглах нь Монголын МСС-ийн бус, зөвхөн МСК-ийн ашиг тусын тулд байх ёстой. МСК-ийн лого болон нэрийг ашиглах нь аливаа агентлаг, эсхүл хуулийн төлөөллийг шинээр бий болгохгүй бөгөөд Монголын МСС нь МСК-д аливаа байдлаар эрх эдлүүлж, үүрэг хүлээлгэх эрхгүй болно.

(b) Монголын МСС нь өөрийн логотой байх бөгөөд тэрхүү лого болон “Монголын Мянганы сорилтын сан,” “Монголын МСС” гэх нэрс тус бүрийг зөвхөн МСК-ийн *Тэмдэг, тэмдэглэгээний олон улсын стандартад* нийцүүлэн ашиглана. Энэхүү Гэрээний 4.2(g) дэх хэсэгт заасны дагуу Монголын МСС нь МСК-д “Монголын Мянганы сорилтын сан,” “Монголын МСС” гэх нэрс болон Монголын МСС-ийн логог ашиглах эрх, лицензийг эргэлт буцалтгүй, үнэ төлбөргүй, дамжуулан ашиглах боломжтой байдлаар олгов.

(c) Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Монголын МСС нь өөрийн лого болон “Монголын Мянганы сорилтын сан,” “Монголын МСС” нэрсийг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй болон цаашид хүчин төгөлдөр үйлчлэх Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулах боломжит бүх арга

хэмжээг авна. Үүнд, эдгээр нэрс болон логог барааны тэмдэг болгон бүртгүүлэх, зохих үед тэдгээрийг гуравдагч этгээд хууль бусаар ашиглаж буй эсэхэд хяналт тавих, хууль бусаар ийнхүү ашиглаж байгаа нь тогтоогдвол хуулиар олгосон эрхээ албадан хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ багтана. Монголын МСС нь МСК-аас зөвшөөрөл аваагүй аливаа гуравдагч тал (i) “Монголын Мянганы сорилтын сан,” “Монголын МСС” гэх нэрс болон/эсхүл Монголын МСС-ийн лого; (ii) “Мянганы сорилтын корпораци,” “МСК” болон/эсхүл МСК-ийн логог тус тус хууль бусаар ашигласан, тийнхүү ашиглах эрсдэл үүссэн талаар мэдсэн даруйдаа МСК-д шуурхай мэдэгдэнэ. Монголын МСС нь “Мянганы сорилтын корпораци,” “МСК” гэх нэрс болон МСК-ийн логотой холбоотой эрхийг хэрэгжүүлэхэд нь МСК-д туслалцаа үзүүлнэ.

2.13 Хэсэг Татвараас чөлөөлөх ажлыг хэрэгжүүлэх.

Компакт гэрээний 2.8 дахь хэсэгт шаардлага болгосны дагуу зарим үндсэн Татвараас хөнгөлөхөд ашиглах механизмыг VI Хавсралтад тусгасан байна. Үүнээс гадна, Засгийн газар нь Компакт гэрээний 2.8 дахь хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд МСК-аас шаардлагатай, эсхүл зохистой хэмээн үзсэн зааварчилгаа, арга хэрэгсэл, эсхүл баримт бичгийг тухай бүр боловсруулан гаргаж, МСК-д хүргүүлэх буюу ийнхүү боловсруулж, хүргүүлэх нөхцөлийг хангана. Эдгээр нэмэлт баталгаанд, Татвараас чөлөөлөх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын төлөөлөгчдөд тодорхой заавар хүргүүлэх зэрэг үйл ажиллагаа, эсхүл Татвараас чөлөөлүүлэх этгээдийг тодорхой заасан Татвараас чөлөөлөх гэрчилгээ зэрэг баримт бичиг багтаж болно.

2.14 Хэсэг Засгийн газрын оруулах хувь хэмжээ

(a) Компакт гэрээний 2.6(a) дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар нь Компакт гэрээний зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн хувь хэмжээг гаргана. Энэхүү хувь хэмжээ нь Компакт гэрээнд гарын үсэг зурахын өмнөх жилийн Улсын төсөвт мөн адил зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд суулгасан аливаа хөрөнгө дээр нэмж тооцогдох бөгөөд МСК-ийн *Буцалтгүй тусламж хүлээн авах орны оруулах хувь хэмжээний тухай зааварчилгаанд* нийцсэн байна. Компакт гэрээ хэрэгжих хугацаанд Засгийн газрын оруулах хувь хэмжээг Төсөл, Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан, зохион байгуулах хүрээнд хэрхэн зарцуулах хуваарилалтыг энэхүү Гэрээний III Хавсралтад тусгана.

(b) Талууд бичгээр өөрөөр тохироогүй бол монгол төгрөг болон бусад орны валютаар илэрхийлсэн Засгийн газрын оруулах хувь хэмжээг ам.доллар руу тэрхүү хувь хэмжээг шилжүүлсэн өдрийн валютын ханшаар хөрвүүлж тооцох, эсхүл Засгийн газрын хувь хэмжээний нийт хугацааны валютын дундаж ханшаар тооцон хөрвүүлэх бөгөөд ингэхдээ Монголбанкнаас зарласан албан ёсны ханш, эсхүл МСК-ийн хүлээн зөвшөөрсөн өөр бусад эх сурвалжийг ашиглана.

(c) Засгийн газар нь өөрийн оруулах хувь хэмжээг удирдан, зохион байгуулахдаа энэхүү Гэрээний IV Хавсралтад заасан зарчим, журамд нийцүүлэхийг үүгээр зөвшөөрөв.

2.15 Хэсэг Засгийн газрын хүлээх нэмэлт үүрэг.

(a) ТЦБ-ийн талаар хийх улирал тутмын уулзалт. ТЦБ-ийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах гэрээнд гарын үсэг зурсан үеэс эхлэн ашиглалтад орох хүртэлх хугацаанд Засгийн газар нь ТЦБ-ийн зураг төсөл, барилга угсралтын ажлыг хариуцсан төслийн нэгж болон Монголын МСС, МСК, тэдгээрийн холбогдох гэрээт зөвлөхүүд, гүйцэтгэгчдийн хооронд улиралд дор хаяж нэг удаа уулзалт зохион байгуулна.

(b) ТЦБ руу нэвтрэх. Засгийн газар нь ТЦБ-ийн барилга угсралтын ажил эхэлсэн үеэс эхлэн ашиглалтад орох хүртэлх хугацаанд Монголын МСС, МСК, тэдгээрийн холбогдох гэрээт зөвлөхүүд, гүйцэтгэгчдийг барилгын талбайд тухай бүр нэвтрэх боломжийг хангана.

(c) ТЦБ-аас гарсан лаг. Засгийн газар нарийвчилсан төлөвлөгөө, одоогийн ТЦБ-аас үүсч буй болон ТЦБ-ын талбайд шинээр үүсэх лагийн овоолгыг устгах, зайлуулах урт хугацааны менежментийн төлөвлөгөөг МСК-ийн шаардлагыг хангахуйц байдлаар боловсруулж хүргүүлнэ.

(d) ТЦБ-ийг барьж дуусгах. Засгийн газар нь Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагааны хүрээнд гаргах худгууд болон дагалдах дэд бүтцийг ашиглалтад оруулахын өмнө ТЦБ-ийг албан ёсоор ашиглалтад оруулсан бөгөөд бүрэн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа, улмаар хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усны чанарт тавигдах Монгол Улсын холбогдох стандарт (MNS4943)-ын шаардлагыг хангасан, эсхүл давсан хаягдал усыг байнга боловсруулан гаргах чадвартай гэсэн нотлох баримтыг МСК-ийн шаардлагыг хангахуйц байдлаар гарган хүргүүлнэ.

3 ДУГААР ЗҮЙЛ МСК-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТ

3.1 Хэсэг Зарцуулалтын үйл явц

(a) Зарцуулалтын хүсэлт. Монголын МСС нь Компакт гэрээний дагуу Зарцуулалт хийх хүсэлтийг (тус бүр **“Зарцуулах хүсэлт”** гэх) тухайн Зарцуулалтын хугацаа эхлэхээс 20 (хорь)-оос доошгүй хоног (эсхүл МСК-ийн зөвшөөрсөн өөр бусад хугацаа)-ийн дотор МСК-ийн Тайлагнах зааварчилгааны дагуу бэлтгэн МСК-д хүргүүлнэ. Хөтөлбөрийн санхүүжилтийн Зарцуулалтын хүсэлт болон Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн Зарцуулалтын хүсэлтийг тус тусын холбогдох маягтын дагуу боловсруулж, тусад нь хүргүүлнэ. МСК-тай бичгээр өөрөөр тохироогүй бол Монголын МСС нь Хөтөлбөрийн санхүүжилтийн Зарцуулалтын хүсэлт болон Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн Зарцуулалтын хүсэлт тус бүрийг улирал (эсхүл МСК-ийн зөвшөөрсөн өөр бусад хугацаа, **“Зарцуулалтын хугацаа”** гэх)-д зөвхөн нэг удаа МСК-д хүргүүлнэ. Зарцуулалтын хүсэлт тус бүрийг хүргүүлэхдээ холбогдох Зарцуулалтын хугацааны Хуваарьт тайланг хавсаргана.

(b) Зарцуулалтыг хүсэлтийг батлах, Шилжүүлэх

(i) МСК нь Зарцуулалтын хүсэлтийг хүлээн авсны дараа тухайн Зарцуулалтын зохих хэмжээг тогтоох бөгөөд дараах болон холбогдох бусад мэдээлэлд суурилна. Үүнд: (А) Хэрэгжилтийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын ахиц, (В) Зарцуулалтын хүсэлтийг дагалдуулан ирүүлсэн Хуваарьт тайланд дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тухайн Зарцуулалтын хугацаанд

шаардагдах санхүүжилтийн хэмжээ, (С) тухайн Зарцуулалтад тавигдах холбогдох нөхцөлүүдийг биелүүлсэн, хэрэгсэхгүй болгосон, эсхүл хойшлуулсан талаарх мэдээлэл багтана. Энэхүү гэрээний 3.1(b)(i) дэх хэсэгт заасан хүчин зүйлсэд тулгуурлан МСК нь Зарцуулалтын хүсэлтэд санал болгосон Зарцуулалтын хэмжээг бүхэлд нь батлахгүй, эсхүл бууруулах шийдвэрийг дангаараа гаргах эрхтэй.

(ii) МСК нь Зарцуулалтын хүсэлтийг батлахаас өмнө тухайн Зарцуулалтад харгалзах дүнг А. Зөвшөөрөл бүхий данс руу, эсхүл Б. Монголын МСС-д тухайн бараа, материалыг нийлүүлсэн, ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн гуравдагч этгээд рүү Төлбөрийн нэгдсэн систем, эсхүл МСК-ийн зөвшөөрсөн төлбөрийн өөр бусад системээр дамжуулан шилжүүлж болох бөгөөд ингэхдээ энэхүү төлбөр (ажил, үйлчилгээ үзүүлсэн этгээд рүү шууд шилжүүлэх дүнг оролцуулан)-ийг Монголын МСС баталгаажуулан зөвшөөрсөн байх, энэхүү төлбөр нь Санхүүгийн дэлгэрэнгүй төлөвлөгөөний хамгийн сүүлд батлагдсан хувилбар болон Санхүүгийн төлөөлөгчтэй байгуулсан гэрээ, Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөнд заасан журам, хэм хэмжээтэй тус тус нийцэж байгаа гэдгийг Санхүүгийн төлөөлөгч хянан баталгаажуулсан байх шаардлагатай.

(c) Зөвшөөрөл бүхий данс

(i) МСК-ийн аливаа санхүүжилтийг МСК-ийн хүлээн зөвшөөрсөн санхүүгийн байгууллагад Монголын МСС-ийн нээлгэсэн, зохих хэмжээгээр хүү хуримтлуулдаг, Монгол Улсын дотоодын валютын данс (тус бүр **“Дотоодын данс”** гэх) руу шилжүүлнэ. Засгийн газрын оруулах хувь хэмжээг шилжүүлэн байршуулахад зориулсан Зөвшөөрөл бүхий данс (**“Засгийн газрын данс”** гэх)-ыг Монголын МСС болон МСК бичгээр харилцан тохирсноор нээнэ. Монголын МСС болон МСК бичгээр харилцан тохирсны дагуу Зөвшөөрөл бүхий данс нэмж нээж болно. Компакт гэрээ хэрэгжих хугацаанд Зөвшөөрөл бүхий аливаа дансны мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд Монголын МСС нь МСК-д тухай бүр шуурхай мэдэгдэж, шинэчлэгдсэн мэдээллийг хүргүүлнэ.

(ii) МСК бичгээр өөрөөр зөвшөөрөөгүй бол МСК-ийн санхүүжилтийг хүлээж авах зориулалттай Зөвшөөрөл бүхий дансанд МСК-ийн санхүүжилт, түүнд тооцсон хүү, холбогдох бусад орлогоос өөр бусад хөрөнгийг хольж байршуулахгүй. Засгийн газрын оруулах хувь хэмжээг Засгийн газрын дансанд байршуулах бөгөөд уг дансанд Засгийн газрын оруулах хувь хэмжээ, түүнд хуримтлагдсан хүүгийн орлогоос өөр бусад хөрөнгийг хольж байршуулахыг хориглоно. МСК нь Зөвшөөрөл бүхий аливаа дансны хуулга, гүйлгээг цахимаар шууд хянах эрхтэй байх бөгөөд ийнхүү хянах боломжгүй тохиолдолд Монголын МСС нь МСК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу дансны хуулгын хувийг тухай бүр хүргүүлнэ. МСК-ийн санхүүжилт болон Засгийн газрын оруулах хувь хэмжээг Зөвшөөрөл бүхий аливаа дансанд байршуулахын өмнө Монголын МСС нь хэлбэр болон агуулгын хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, гарын үсэг зурах эрх, нэвтрэх эрх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг заалтууд болон Монголын МСС-ийн Зөвшөөрөл бүхий данстай холбоотой бусад заалтуудыг агуулсан гэрээ (**“Банкны гэрээ”** гэх)-г МСК-ийн зөвшөөрсөн санхүүгийн байгууллага (**“Банк”** гэх)-тай байгуулна. Зөвхөн Санхүүгийн төлөөлөгч, эсхүл Банкны гэрээнд тусгайлан заасан тохиолдолд МСК-ийн зөвшөөрөл бүхий төлөөлөгч нь Зөвшөөрөл бүхий дансны гүйлгээнд гарын үсэг зурах эрхтэй байна.

(iii) Зөвшөөрөл бүхий дансанд байршуулсан МСК-ийн санхүүжилт, эсхүл Засгийн газрын оруулах хувь хэмжээнд тухайн Банкны гэрээний дагуу хүүгийн, эсхүл холбогдох бусад орлогыг тооцон хуримтлуулж болно. Улирал тутам, түүнчлэн Компакт гэрээ эсхүл Банкны гэрээ хүчингүй болсон, дуусгавар болсон тохиолдолд Монголын МСС нь МСК-ийн санхүүжилтэд тооцон хуримтлагдсан хүүгийн бүх орлогыг МСК руу шилжүүлнэ. Зөвшөөрөл бүхий дансанд байрлах Засгийн газрын оруулах хувь хэмжээнд тооцсон хүүг Засгийн газар болон тухайн Банкны хооронд харилцан тохиролцсон журмын дагуу Засгийн газарт шилжүүлнэ.

(iv) МСК бичгээр өөрөөр зөвшөөрөөгүй бол, Монголын МСС нь МСК-ийн санхүүжилтийг Дотоодын данснаас өөр Зөвшөөрөл бүхий дансанд байршуулсан тохиолдолд тэрхүү санхүүжилтийг Дотоодын данс руу шилжүүлэх, эсхүл зарцуулахын өмнө ам.доллар руу хөрвүүлнэ. Монголын МСС нь ам.доллараар илэрхийлэгдсэн МСК-ийн санхүүжилтийг төгрөг рүү хөрвүүлсэн тохиолдолд Банкны гэрээ болон холбогдох бусад Нэмэлт гэрээнд заасан шаардлагад нийцүүлнэ.

3.2 Хэсэг Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтээс хийх Зарцуулалтад тавигдах урьдчилсан болзолт нөхцөлүүд.

Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтээс хийх эхний болон дараа дараагийн Зарцуулалтын өмнө Компакт гэрээний IV Хавсралтад заасан холбогдох нөхцөлүүдийг МСК-ийн шаардлагад нийцүүлэн хангасан байна.

3.3 Хэсэг Хөтөлбөрийн санхүүжилтээс хийх эхний Зарцуулалтад тавигдах урьдчилсан болзолт нөхцөлүүд.

МСК-ийн зүгээс хэрэгсэхгүй болгосон, эсхүл хойшлуулснаас бусад тохиолдолд Хөтөлбөрийн санхүүжилтээс хийх эхний Зарцуулалтыг гүйцэтгэхийн өмнө энэхүү 3.3 дахь хэсгийн дараах нөхцөлүүд болон 3.4 дэх хэсэгт заасан нөхцөлүүдийг МСК-ийн шаардлагад нийцүүлэн хангасан байх шаардлагатай. Үүнд:

(a) Компакт гэрээ хүчин төгөлдөр болох. Компакт гэрээ нь Компакт гэрээний 7 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болсон байх.

(b) Үндсэн ажилтан. Бүх үндсэн ажилтныг Монголын МСС сонгон шалгаруулан, гэрээ байгуулж, МСК-аар батлуулсан байх.

(c) Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө. Монголын МСС нь Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө (эсхүл түр хувилбар)-г боловсруулж, МСК-аар батлуулсан байх.

(d) Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө. Эхний Зарцуулалт Компакт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 90 дэх хоног дээр, эсхүл түүнээс хойш хийгдэж байгаа тохиолдолд, Монголын МСС нь Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж, Удирдах зөвлөл болон МСК-аар батлуулсан байх.

(e) Хэрэгжилтийн төлөвлөгөө. Монголын МСС нь Хэрэгжилтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулсан байх.

(f) Засаглалын баримт бичиг. Засгийн газар нь Монголын МСС-г байгуулах, үйл ажиллагааг зохих ёсоор эхлүүлэхэд шаардлагатай баримт бичгийг батлан гаргасан байх бөгөөд ингэхдээ холбогдох хууль тогтоомж, тогтоол, дүрэм журамд нийцүүлсэн байх.

3.4 Хэсэг Хөтөлбөрийн санхүүжилтээс хийх Зарцуулалт бүрт тавигдах урьдчилсан болзолт нөхцөлүүд.

МСК-ийн зүгээс хэрэгсэхгүй болгосон, эсхүл хойшлуулснаас бусад тохиолдолд Хөтөлбөрийн санхүүжилтээс хийх Зарцуулалт бүрийг (Хөтөлбөрийн санхүүжилтээс хийх эхний Зарцуулалтыг оролцуулан) гүйцэтгэхийн өмнө дараах нөхцөлүүдийг МСК-ийн шаардлагад нийцүүлэн хангасан байх шаардлагатай. Үүнд:

(a) Хүлээлгэн өгөх баримт бичиг. Монголын МСС нь дараах баримт бичиг, тайлан, мэдээллийг агуулга, хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, МСК-д хүргүүлнэ. Үүнд:

(i) зохих ёсоор бөглөсөн Зарцуулалтын хүсэлтийн маягыг тухайн Зарцуулалтын хугацаанд хамаарах Хуваарьт тайлангийн хамт,

(ii) Монголын МСС-тай хамтран ажиллаж буй мэргэжлийн аливаа аудитор (байгаль орчны аудиторыг оролцуулан)-ын өмнөх Зарцуулалтын хүсэлтийг хүргүүлснээс хойших хугацаанд гүйцэтгэсэн аливаа аудитын тайлангийн хувь;

(iii) Зарцуулалтын хүсэлт хүргүүлсэн өдрөөр огноолсон, МСК-аас ирүүлсэн загварын дагуу боловсруулсан Монголын МСС-ийн баталгаа (**“Монголын МСС-ийн Зарцуулалтын баталгаа”** гэх);

(iv) МСК-аас ирүүлсэн загварын дагуу боловсруулсан Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн баталгаа (**“Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн баталгаа”** гэх);

(v) МСК-аас ирүүлсэн загварын дагуу боловсруулсан Санхүүгийн төлөөлөгчийн баталгаа (**“Санхүүгийн төлөөлөгчийн баталгаа”** гэх).

(b) Урьдчилсан болзолт бусад нөхцөлүүд. МСК нь дараах урьдчилсан болзолт нөхцөлүүдийг бие даан тодорхойлсон болно. Үүнд:

(i) II Хавсралтад заасан холбогдох бүх урьдчилсан болзолт нөхцөлүүдийг энэхүү Гэрээнд заасны дагуу зохих ёсоор хангасан, хойшлуулсан, эсхүл хэрэгсэхгүй болгосон байх;

(ii) Засгийн газар, Монголын МСС, Засгийн газрын аливаа бусад байгууллага Компакт гэрээ, энэхүү Гэрээ, эсхүл холбогдох бусад Нэмэлт гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалт, хариуцлагаа зөрчөөгүй, үл биелүүлээгүй байх.

(iii) Энэхүү Зарцуулалтаар санхүүжүүлэх аливаа үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчөөгүй байх;

(iv) Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичгүүд болон Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөг хэлбэр, агуулгын хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн эцсийн байдлаар шинэчилсэн бөгөөд Компакт гэрээний урьдчилсан санхүүжилтийн тухайн Зарцуулалтад хамаарах аливаа Үйл ажиллагааны Хэрэгжилтийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэгт МСК-ийн шаардлагыг хангахуйц ахиц дэвшил гарсан байх;

(v) Хөтөлбөрийн болон Төсөл эсхүл холбогдох Үйл ажиллагааны Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө болон Нийгэм, жендэрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах төлөвлөгөөний чиглэлээр МСК-ийн шаардлагад нийцэхүйц ахиц тус тус гарсан, түүнчлэн Мониторинг, үнэлгээний төлөвлөгөө болон Нийгэм, жендэрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах төлөвлөгөөнд багтсан шаардлагууд (эдгээр төлөвлөгөөнд туссан болон тухайн Зарцуулалтын хугацаанд хамаарах зорилтот түвшин, тайлангийн шаардлагууд оролцуулан)-ыг бодитойгоор хангасан байх;

(vi) Хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцож буй Засгийн газрын бүх байгууллага, түүний дотор Хэрэгжүүлэгч байгууллагууд, Монголын МСС-тай уялдаа холбоотой, нягт хамтран ажиллаж, Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц болон бусад нөөцөөр хангаж ажиллаж байх,

(vii) Компакт гэрээ болон Аудитын төлөвлөгөөний дагуу хүргүүлсэн сүүлийн хоёр улирал (эсхүл Аудитын төлөвлөгөөнд шаардлага болгосон бусад хугацаа)-ын санхүүгийн аудитын тайланд сөрөг дүгнэлт байхгүй байх;

(viii) холбогдох Зарцуулалтыг хийх хугацаанаас өмнөх 90 (ер) хоногийн дотор МСК-ийн хөрөнгөөр төлсөн аливаа Татварын үнийн дүнг Засгийн газраас Компакт гэрээний 2.8(с) дэх Хэсгийн дагуу бүхэлд нь буцаан төлсөн байх;

(ix) Засгийн газар хүлээсэн төлбөрийн бүх үүрэг хариуцлага, түүний дотор даатгал, нөхөн төлбөр, татварын болон бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн бөгөөд шаардлагатай бүх эх үүсвэрийг Компакт гэрээ, энэхүү Гэрээ болон холбогдох Нэмэлт гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу хариуцан гаргасан байх;

(x) МСК нь Монголын МСС-ийн Санхүүжилтийн зарцуулалтын маягт, Санхүүгийн асуудал хариуцсан төлөөлөгчийн зарцуулалтын баталгаа, Худалдан авах ажиллагаа хариуцсан төлөөлөгчийн баталгаанд хамаарах аливаа асуудлыг баталгаажаагүй гэж үзэх үндэслэлгүй байх;

(xi) Компакт гэрээний 5.1 дэх хэсгийн дагуу МСК Компакт гэрээ болон МСК-ийн санхүүжилтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох эсхүл хүчингүй болгох үндэслэл болохуйц үйлдэл, эс үйлдэл, нөхцөл байдал, үйл явдал үүсээгүй байх;

(xii) Монголын МСС-ийн Үндсэн ажилтнууд үүрэгт ажлаа хэвийн гүйцэтгэж байх, улмаар орон тоо сул байгаа тохиолдолд уг орон тоонд авах хүнийг сонгон шалгаруулах ажиллагааг Монголын МСС идэвхтэй гүйцэтгэж байгаа гэж МСК үзсэн байх;

(xiii) Монголын МСС нь санал, гомдол хүлээн авч, шийдвэрлэх журмыг боловсруулан батлах хүрээнд энэхүү Гэрээний 2.1(d) дэх хэсгийн дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байх;

(xiv) Засгийн газар нь өөрийн оруулах хувь хэмжээг энэхүү Гэрээний III Хавсралтад заасан цаг хугацааны хуваарийн дагуу, IV Хавсралтад заасан Хэрэгжилтийн бүтцэд нийцүүлэх гүйцэтгэхтэй холбоотой энэхүү Гэрээний 2.14 дэх хэсгийн дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байх зэрэг болно.

3.5 Хэсэг Зөвшөөрөгдсөн зардал.

МСК-аас бичгээр өөрөөр зөвшөөрөөгүй бол, МСК-ийн санхүүжилтээс аливаа Зарцуулалт хийж, эсхүл санхүүгийн үүрэг хариуцлага хүлээх бол холбогдох зардлыг Санхүүгийн дэлгэрэнгүй төлөвлөгөөнд зайлшгүй тусгасан бөгөөд холбогдох хугацаанд үлдэгдэл санхүүжилт хангалттай байх ёстой бөгөөд ийм тохиолдолд л холбогдох Зарцуулалтын хүсэлтийг хүргүүлж болно.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ ЭНЭХҮҮ ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, КОМПАКТ ГЭРЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ҮЙЛЧЛЭЛИЙГ ТҮР ЗОГСООХ, ДУУСГАВАР БОЛГОСНООР ГАРАХ ҮР ДАГАВАР

4.1 Хэсэг Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох.

Талууд энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд энэхүү Гэрээний нөхцөлүүдийг урьдчилан хэрэгжүүлэхээр зөвшөөрсөн тохиолдолд энэхүү Гэрээ нь (а) Талууд тус бүр энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан огноо, эсхүл (б) Компакт гэрээний 7 дугаар зүйлд заасны дагуу Компакт гэрээ хүчин төгөлдөр болсон огнооны аль хожуу тохиох өдрөөр огноолон хүчин төгөлдөр болно.

4.2 Хэсэг Компакт гэрээг хүчингүй болгох, үйлчлэлийг түр зогсоох, эсхүл дуусгавар болгосноор гарах үр дагавар.

(а) Компакт гэрээний үйлчлэл, эсхүл МСК-ийн аливаа санхүүжилтийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түр зогсоосон тохиолдолд холбогдох бүх Зарцуулалтыг мөн түр зогсоох бөгөөд МСК нь аливаа Зөвшөөрөгдсөн дансанд байршуулсан МСК-ийн санхүүжилт (эсхүл түүний тодорхой хэсэг)-ийг буцаан шилжүүлэхийг Засгийн газраас хүсэх эрхтэй бөгөөд энэ хугацаанд МСК-ийн санхүүжилтийг Компакт гэрээ болон энэхүү Гэрээнд нийцүүлэн, МСК-ийн бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу (i) Компакт гэрээний үйлчлэл, эсхүл МСК-ийн аливаа санхүүжилтийг түр зогсоохын өмнө Хөтөлбөрийн дагуу, эсхүл түүний хэрэгжилтийг хангах хүрээнд зохих ёсоор худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг төлөх, (ii) Компакт гэрээний үйлчлэл, эсхүл МСК-ийн аливаа санхүүжилтийг түр зогсоосонтой холбогдон гарсан, үндэслэл бүхий зардлыг санхүүжүүлэхэд тус тус зарцуулж болно.

(b) Компакт гэрээ, эсхүл МСК-ийн аливаа санхүүжилтийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хүчингүй болгосон тохиолдолд холбогдох бүх Зарцуулалтыг зогсоох бөгөөд энэ хугацаанд МСК-ийн санхүүжилтийг Компакт гэрээ болон энэхүү Гэрээнд нийцүүлэн, МСК-ийн бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу (i) Компакт гэрээ, эсхүл МСК-ийн аливаа санхүүжилтийг хүчингүй болгохын өмнө Хөтөлбөрийн дагуу, эсхүл түүний хэрэгжилтийг хангах хүрээнд зохих ёсоор худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг төлөх; (ii) Компакт эсхүл МСК-ийн аливаа санхүүжилтийг хүчингүй болгосноос хойш 120 хоногийн дотор Хөтөлбөрийг зогсоохтой холбогдон гарсан, үндэслэл бүхий зардал (захиргааны зардлыг оролцуулан)-ыг санхүүжүүлэхэд тус тус зарцуулж болно.

(c) Компакт гэрээ дуусгавар болсон тохиолдолд бүх Зарцуулалтыг зогсоох бөгөөд энэ хугацаанд МСК-ийн санхүүжилтийг Компакт гэрээ болон энэхүү Гэрээнд нийцүүлэн, МСК-ийн бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу (i) Компакт гэрээ, дуусгавар болохын өмнө Хөтөлбөрийн дагуу, эсхүл түүний хэрэгжилтийг хангах хүрээнд зохих ёсоор худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг төлөх; (ii) Компакт гэрээ дуусгавар болсноос хойш дээд тал нь хуанлийн 120 хоног үргэлжилж болох Хаалтын хугацаанд Хөтөлбөрийг зогсоохтой холбогдон гарсан, үндэслэл бүхий зардал (захиргааны зардлыг оролцуулан)-ыг *МСК-ын Хаалтын зааварчилгаа* болон *МСК-ийн Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч этгээдийн зардлын зарчмуудын* дагуу санхүүжүүлэхэд тус тус зарцуулж болно.

(d) Компакт гэрээ, эсхүл МСК-ийн аливаа санхүүжилт дуусгавар болсон, эсхүл хүчингүй болсон тохиолдолд энэхүү Гэрээний 4.2(b) болон 4.2(c) дэх хэсгийн дагуу аливаа Зөвшөөрөл бүхий данс дахь, дуусгавар болох, эсүл хүчингүй болох үед зарцуулаагүй үлдсэн МСК-ийн аливаа санхүүжилтийг буцаан шилжүүлэх бөгөөд ингэхдээ ийнхүү шилжүүлэх тухай хүсэлтийг МСК-аас хүлээн авснаас хойш 30

хоногийн дотор тэрхүү санхүүжилтэд тооцон хуримтлагдсан хүүгийн орлогыг мөн хамт шилжүүлнэ. Компакт гэрээг хэсэгчлэн хүчингүй болгосон тохиолдолд зөвхөн хүчингүй болгосон тэрхүү хэсэгт хамаарах МСК-ийн санхүүжилтийг МСК-д буцаан шилжүүлнэ.

(e) Компакт гэрээ, эсхүл МСК-ийн аливаа санхүүжилтийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгосон тохиолдолд, МСК нь шилжүүлж болохуйц нөхцөлд буй Хөтөлбөрийн өмч хөрөнгийг өөрийн зардлаар шилжүүлэн авах эрхтэй бөгөөд Засгийн газар нь МСК-аас ийнхүү чиглэл ирүүлсэн даруйд шуурхай гүйцэтгэнэ. Ийнхүү шилжүүлэх боломжгүй Хөтөлбөрийн өмч хөрөнгө болон МСК-ийн санхүүжилтээр хэсэгчлэн санхүүжүүлж худалдан авсан аливаа Хөтөлбөрийн аливаа өмч хөрөнгийн тухайд Засгийн газар нь МСК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу, Хөтөлбөрийн тэрхүү өмч хөрөнгийн зах зээлийн бодит үнэлгээнд МСК-ийн эзлэх хувь хэмжээг тогтоож ирүүлсний дагуу ам.доллараар тооцон МСК-д нөхөн төлнө.

(f) Компакт гэрээ дуусгавар болох, эсхүл хүчингүй болохын өмнө Монголын МСС нь Хөтөлбөрийн хаалтын зааварчилгааны дагуу Компакт гэрээний хаалтын төлөвлөгөө боловсруулж, түүнд заасан шаардлагуудыг сахин биелүүлнэ.

(g) МСК бичгээр өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд, Компакт гэрээ дуусгавар болсон, эсхүл хүчингүй болсноос хойш 120 хоногийн дотор, (i) энэхүү Гэрээний 2.12(a) дэх хэсгийн дагуу Монголын МСС-д олгосон лицензийг нэн даруй хүчингүй болно, (ii) Засгийн газар Монголын МСС-ийн “Монголын Мянганы Сорилтын Сан” болон/эсхүл “Монголын МСС” гэсэн нэршлийг цуцлах зохих арга хэмжээ авна; (iii) Засгийн газар нь МСК-аас зөвшөөрөл аваагүй аливаа этгээд, аливаа зорилгоор “Мянганы сорилтын корпораци,” “МСК” гэсэн нэрс болон холбогдох аливаа логог хэрэглэхийг зогсоох арга хэмжээ авна. Улмаар, Компакт гэрээ дуусгавар болсон, эсхүл хүчингүй болсноор Монголын МСС нь энэхүү Гэрээ хэрэгжих хугацаанд “Монголын Мянганы сорилтын сан,” “Монголын МСС,” “Мянганы сорилтын корпораци,” “МСК” гэсэн нэрс болон Монголын МСС, МСК-ийн логотой холбоотой эдэлж байсан бүх эрх, сонирхлыг шилжүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд үүгээр шилжүүлж байна.

(h) МСК болон Засгийн газрын хувьд Компакт гэрээний үр нөлөөг урт удаан хугацаанд үргэлжилнэ гэсэн хүлээлттэй байгаа бөгөөд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад үзүүлэх үр нөлөө нь Компакт гэрээ дуусгавар болох болон цуцлагдсанаас хойш хэдэн жилд хэмжигдэхүйц биш байж болно гэж үзэж байна. Тиймээс МСК, Засгийн газар нь Компакт гэрээний хугацаа дуусгавар болсон болон цуцлагдсаны дараа эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулахад Компакт гэрээний үзүүлсэн үр дүнг хамтран хянах, үр нөлөөг үнэлэхээр тохиролцсон байна. Энэхүү хамтын ажиллагааны нэг хэсэг болгож Компакт гэрээний хугацаа дуусахаас өмнө эсхүл цуцлагдмагц энэхүү гэрээний 4.2 (f) заалтад тусгасан үйл ажиллагаанаас гадна Компакт гэрээ дууссаны дараах хяналтын ба үнэлгээний төлөвлөгөө, эдгээр үйл ажиллагааг явуулах хувь хүн, байгууллага, хяналт ба үнэлгээний төсвийн хүрээ зэргийг боловсруулна. Гэсэн хэдий ч энэхүү Гэрээний 4.2 (h) заалт нь Компакт гэрээний хугацаа дуусгавар болсон эсхүл цуцлагдсанаас хойш МСК-ийн зүгээс Засгийн газарт туслалцаа үзүүлэх талаар үүрэг хүлээсэн гэж тайлбарлагдахгүй болно. Засгийн газар нь Компакт гэрээний дараах хяналт, үнэлгээний төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагатай бүхий л нөөцөөр (санхүү болон боловсон хүчин зэрэг багтана) хангахаа зөвшөөрсөн болно.

5 ДУГААР ЗҮЙЛ ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

5.1 Хэсэг Төлөөлөгчид.

Компакт гэрээний 4.2 дахь хэсгийг энэ хэсэгт бүхэлд нь ишлэл болгон оруулснаар тооцов.

5.2 Хэсэг Харилцаа холбоо.

Мянганы сорилтын Компакт гэрээний 4.1 дэх хэсэг энэ заалтын салшгүй нэг хэсэг болон үйлчилнэ. Монголын мянганы сорилтын сан байгуулагдмагц талуудад холбогдох мэдээллээ ирүүлнэ.

5.3 Хэсэг Засгийн газрийн эрх, үүргийг шилжүүлэх.

Засгийн газар нь МСК-аас урьдчилан бичгээр авсан зөвшөөрөлгүйгээр энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх, төлөөлүүлэх, эсхүл гэрээлэхийг хориглоно. МСК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу, Засгийн газар нь МСК-ийн санхүүжилтээс бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн санхүүжсэн аливаа гэрээний гүйцэтгэл, эсхүл зөрчилтэй холбоотойгоор Засгийн газарт эсхүл Монголын МСС-д үүсэх гэрээний эрх, баримтыг МСК-д шилжүүлж болно.

5.4 Хэсэг Нэмэлт өөрчлөлт; Эрх үүргээс татгалзах.

Талууд зөвхөн бичгээр харилцан тохиролцсоны дагуу энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд бичгээр ийнхүү тохиролцохдоо тухайн нэмэлт, өөрчлөлт хэрхэн хүчин төгөлдөр болох талаар мөн заана. Засгийн газар болон МСК нь үүнтэй холбогдуулан аливаа хавсралтад өөрчлөлт оруулах бол уг өөрчлөлтөд тус бүрийн Үндсэн төлөөлөгч, эсхүл Нэмэлт төлөөлөгч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Энэхүү Гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулахад Засгийн газраас нэмэлт үйл ажиллагаа (хууль тогтоох байгууллагаар хэлэлцүүлэх зэрэг) явуулах, эсхүл дотоодын аливаа нэмэлт шаардлагыг хангах шаардлагагүй гэдгийг Талууд ойлгож байгаа болно. Энэхүү Гэрээтэй холбогдуулан аливаа эрх, үүргээс татгалзахдаа зөвхөн бичгээр үйлдсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.

5.5 Хэсэг Хавсралтууд.

Энэхүү Гэрээнд хавсаргасан хүснэгт, хуваарь, хавсралт бүр энэхүү Гэрээний салшгүй хэсэг болно.

5.6 Хэсэг Үл нийцэл.

Энэхүү Гэрээ болон Компакт гэрээний хооронд аливаа зөрчил, үл нийцэл гарсан тохиолдолд Компакт гэрээг баримтална. Энэхүү Гэрээ болон аливаа бусад Нэмэлт Гэрээ, эсхүл Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичгийн хооронд аливаа зөрчил, үл нийцэл гарсан тохиолдолд энэхүү Гэрээг баримтална.

5.7 Хэсэг Энэхүү Гэрээг хүчингүй болгох.

(а) МСК нь Засгийн газарт 30 (гуч) хоногийн дотор бичгээр мэдэгдсэнээр энэхүү Гэрээг аливаа шалтгаан заалгүйгээр хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгож

болно. Компакт гэрээний 5.1(a) дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар Компакт гэрээг хүчингүй болгосон тохиолдолд энэхүү Гэрээ нэгэн зэрэг хүчингүй болно.

(b) МСК нь Компакт гэрээний 5.1(b) дэх хэсэгт заасны дагуу Компакт гэрээ, эсхүл МСК-ийн санхүүжилтийг хүчингүй болгох, эсхүл түр зогсоох үндэслэл болохуйц аливаа үйл явдал тохиолдсон гэж үзвэл, Монголын МСС болон Засгийн газарт бичгээр мэдэгдсэний дагуу энэхүү Гэрээг нэн даруй бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгож болно.

(c) Энэхүү Гэрээг дээр дурдсан нөхцөлийн дагуу хугацаанаас нь өмнө хүчингүй болгосноос бусад тохиолдолд Компакт гэрээ дуусгавар болох, эсхүл хүчингүй болгоход нэгэн зэрэг хүчингүй болох бөгөөд харин МСК энэхүү Гэрээний 4.2(b) эсхүл (c) дэх хэсэгт заасны дагуу Компакт гэрээ дуусгавар болох, эсхүл хүчингүй болгохоос өмнө (МСК-ийн хүлээн авч, баталсан Зарцуулалтын хүсэлтийн дагуу) үүссэн төлбөрийн аливаа үүргийг барагдуулах шаардлагатай гэж тогтоосон тохиолдолд төлбөрийн тэрхүү үүргийг барагдуулах өдөр хүртэл энэхүү Гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

5.8 Хэсэг Үйлчлэл хэвээр хадгалагдах.

Энэхүү Гэрээ дуусгавар болсон, үйлчлэлийг түр зогсоосон, хүчингүй болгосноос үл хамааран Гэрээний 1.2 (b)(i), 1.2(b)(ii), 2.11, 4.2, 5.1, 5.2, 5.3, 5.8, 5.9, 5.10 дахь хэсгийн үйлчлэл хүчинтэй хэвээр хадгалагдана.

5.9 Хэсэг МСК-д хүргүүлсэн мэдээлэл.

МСК нь Хөтөлбөртэй холбоотой боловсруулсан, эсхүл хүргүүлсэн аливаа Зарцуулалтын хүсэлт, тайлан, баримт бичиг дэх аливаа мэдээллийг ашиглаж, эсхүл (a) өөрийн ажилтнууд, гүйцэтгэгчид, төлөөлөгчдөд, (b) АНУ-ын аливаа ерөнхий хянан шалгагч, эсхүл АНУ-ын Засгийн газрын хариуцлагатай байдлын алба, эсхүл МСК-ийн дотоод тайлангийн шаардлагыг хангах аливаа зорилгоор, (c) тодорхой мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох зорилгоор МСК-ийн цахим хуудсанд байрлуулах, (d) МСК болон түүний хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн талаар олон нийтэд сурталчлах, (e) бусад хэлбэрээр танилцуулж болно.

5.10 Хэсэг Хэрэглэх хууль.

Энэхүү Гэрээ нь Компакт гэрээг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан олон улсын гэрээ мөн, иймд Компакт гэрээтэй нэгэн ижил хүрээнд ойлгох бөгөөд олон улсын эрх зүйгээр зохицуулагдана гэдгийг Талууд ойлгож, хүлээн зөвшөөрөв.

5.11 Хэсэг Гарын үсэг.

Энэхүү Гэрээ болон Гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг нэг хуудаст гарын үсэг зурах, эсхүл захидал буюу дипломат ноот бичигт солилцохыг жинхэнэ эх бичвэрт гарын үсэг зурсан гэж үзнэ

ГАРЫН ҮСЭГ ДАРААГИЙН ХУУДАСТ ЗУРАГДАНА

ҮҮНИЙГ ГЭРЧИЛЖ, Талууд зохих ёсоор бүрэн эрх олгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан энэхүү Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээг 2019 оны .. дугаар сарын ..-ний өдөр байгуулав.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМААР
ТӨЛӨӨЛҮҮЛЭН
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МЯНГАНЫ СОРИЛТЫН КОРПОРАЦИАР
ТӨЛӨӨЛҮҮЛЭН
АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Гарын үсэг: _____
Нэр: ДАМДИНЫ ЦОГТБААТАР
Албан тушаал:

Гарын үсэг: _____
Нэр:
Албан тушаал:

I ХАВСРАЛТ НЭР ТОМЬЁО

Гэрээ гэж энэхүү Гэрээний Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Аудитын төлөвлөгөө гэж энэхүү Гэрээний 2.1(с) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Аудитор гэж энэхүү Гэрээний 2.10(с) хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Аудитор/Хянан шалгагчийн гэрээ гэж энэхүү Гэрээний 2.10(с) хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Банк гэж энэхүү Гэрээний 3.1 (с)(ii) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Банктай байгуулсан хүчин төгөлдөр гэрээ гэж энэхүү Гэрээний 3.1(с)(ii) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Санал, гомдол хүлээн авч, шийдвэрлэх журам гэж энэхүү Гэрээний 2.1.(d) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Журам гэж энэхүү Гэрээний 1.3(b)(v) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ..

Төлбөрийн нэгдсэн систем гэж Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тайлбарласан, МСК-ийн санхүүжилтээс гүйцэтгэх төлбөрүүдийг нийлүүлэгчдэд шууд шилжүүлдэг системийг хэлнэ.

Компакт гэрээ гэж энэхүү Гэрээний Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээ дуусгавар болох огноо гэж МСК-ийн Хөтөлбөрийн хаалтын зааварчилгаанд заасан утгыг илэрхийлнэ.

Нөгөө тал гэж энэхүү Гэрээний 1.3(b)(vi) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Оноосон эрх, үүрэг хариуцлага гэж энэхүү Гэрээний 1.3(a)(i) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Санхүүгийн дэлгэрэнгүй төлөвлөгөө гэж энэхүү Гэрээний 2.1(b) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Зарцуулалтын хугацаа гэж энэхүү Гэрээний 3.1(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Зарцуулалтын хүсэлт гэж энэхүү Гэрээний 3.1(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) гэж санал болгож буй бизнесийн үйл ажиллагаа, төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг урьдчилан таамаглах, тодорхойлох, үнэлж дүгнэх, улмаар тэдгээрийн боломжит хувилбаруудыг харьцуулж үзэх, байгаль орчны нийгмийн нөлөөллийн сөрөг нөлөөллийг саармагжуулах, зохицуулах, хяналт тавих арга хэмжээг хэлнэ.

Байгаль орчны нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) гэж БОННУ-ээр илэрсэн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, эрсдэл, үүсэх үүрэг хариуцлагыг төслийн барилга угсралт, үйл ажиллагаа, хаалтын шатанд үр дүнтэйгээр удирдан, зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлсон төлөвлөгөө, эсхүл стратегийг хэлнэ.

Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС) гэж аливаа байгууллага өөрийн захиалагч, хөрөнгө оруулагч, холбогдох талуудад учирч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэлийг олж тогтоох, хянан зохицуулах бодлого, дүрэм, журам, арга хэрэгсэл болон дотоод нөөц бололцоог хэлнэ.

Чөлөөлөлтөд хамрагдах этгээд гэж энэхүү Гэрээний V Хавсралтын оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Чөлөөлөлтөд хамрагдах хувь хүн гэж энэхүү Гэрээний V Хавсралтын оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө гэж энэхүү Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Санхүүгийн төлөөлөгчийн гэрээ гэж энэхүү Гэрээний 2.10(b) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Санхүүгийн төлөөлөгчийн Зарцуулалтын баталгаа гэж энэхүү Гэрээний 3.4(a)(v) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Санхүүжилт бүхий гэрээ гэж энэхүү Гэрээний 1.3(b)(vi) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Ерөнхий заалтуудын хавсралт гэж МСК-ийн цахим хуудаст нийтэлсэн, эсхүл өөр бусад байдлаар Засгийн газарт танилцуулсан Ерөнхий заалтуудын хавсралт гэх нэртэй баримт бичгийг хэлнэ.

Засаглалын зааварчилгаа гэж Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч этгээд болон Хэрэгжилтийн бүтцэд зориулсан МСК-ийн зааварчилгааг хэлнэ.

Үндсэн баримт бичиг гэж энэхүү Гэрээний 2.9(g) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Засгийн газар гэж энэхүү Гэрээний Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Засгийн газрын данс гэж энэхүү Гэрээний 3.1(c)(i) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Засгийн газрын оруулах хувь хэмжээ гэж энэхүү Гэрээний 2.13(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Олон улсын санхүүгийн корпорацийн гүйцэтгэлийн стандарт гэж энэхүү Гэрээний 1.3(b)(v) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хэрэгжилтийн төлөвлөгөө гэж энэхүү Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичиг гэж энэхүү Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Үндсэн ажилтнууд гэж Засаглалын зааварчилгаанд заасныг хэлнэ.

Барьцаалах гэж энэхүү Гэрээний 1.2(b)(i) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Дотоодын данс гэж энэхүү Гэрээний 3.1(c)(i) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Үндсэн гэрээ гэж энэхүү Гэрээний 2.9(c) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Монголын МСС-ийн Зарцуулалтын гэрчилгээ гэж энэхүү Гэрээний 3.4(a)(iii) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Монголын МСС гэж энэхүү Гэрээний 1.3(a)(i) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Монголын МСС-ийн цахим хуудас гэж энэхүү Гэрээний 2.11(b) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Мянганы сорилтын корпораци гэж энэхүү Гэрээний Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Компакт гэрээ хэрэгжих хугацааны санхүүгийн төлөвлөгөө гэж энэхүү Гэрээний 2.1(b) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Ажиглагч гэж Засаглалын зааварчилгаанд заасан утгыг илэрхийлнэ.

Төслийн хөндлөнгийн менежер гэж энэхүү Гэрээний 2.10(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Тал болон Талууд гэж энэхүү Гэрээний Оршил хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Хуваарьт тайлан гэж энэхүү Гэрээний 2.8(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Зөвшөөрөл бүхий данс гэж энэхүү Гэрээний 1.2(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн гэрээ гэж энэхүү Гэрээний 2.10(d) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Худалдан авах ажиллагааны төлөөлөгчийн Зарцуулалтын гэрчилгээ гэж энэхүү Гэрээний 3.4(a)(iv) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэж энэхүү Гэрээний 2.1(d) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааны төлөвлөгөө (НСУАТ) гэж төсөл хэрэгжсэний улмаас хүн амыг албадан шилжүүлснээс үүдэн гарах нөлөөллийг саармагжуулахад чиглэсэн төлөвлөгөөг хэлнэ.

Нүүлгэн суурьшуулах бодлогын баримт бичиг (НСБББ) гэж тухайн төсөлд зориулан, Дэлхийн банкны албадан нүүлгэн суурьшуулах үед баримтлах бодлогод (ОР 4.12) нийцүүлэн боловсруулсан, төслийн хэрэгжилтийн шатанд нүүлгэн суурьшуулалттай холбогдуулан үүсч болзошгүй аливаа нөхцөл байдлыг зохицуулах зарчим, бүтэц, зохион байгуулалтын шалгууруудыг заан тодорхойлсон өргөн цар хүрээ бүхий төлөвлөгөө, эсхүл схемийг хэлнэ.

Хянан шалгагч гэж энэхүү Гэрээний 2.10(c) дэх хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Нийгэм, жендэрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах төлөвлөгөө гэж энэхүү Гэрээний 2.5 дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

Ажлын төлөвлөгөө гэж энэхүү Гэрээний 2.1(a) дахь хэсэгт заасан утгыг илэрхийлнэ.

II ХАВСРАЛТ

ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТЭД ТАВИГДАХ НЭМЭЛТ УРЬДЧИЛСАН БОЛЗОЛТ НӨХЦӨЛҮҮД

Энэхүү Гэрээний 3.2, 3.3 болон 3.4 дэх хэсэгт заасан урьдчилсан болзолт нөхцөлүүдээс гадна дараах нэмэлт урьдчилсан болзолт нөхцөлүүдийг (МСК хэрэгсэхгүй болгосон, эсхүл хойшлуулснаас бусад тохиолдолд) МСК-ийн шаардлагад нийцүүлэн хангах шаардлагатай.

А ХЭСЭГ. Зарцуулалтын хүсэлтэд бүхэлд нь тавигдах Урьдчилсан болзолт нөхцөлүүд.

(i) Хөтөлбөрийн санхүүжилтээс хоёр дахь удаа Зарцуулалт хийхийн өмнө Монголын МСС нь Нийгэм, жөндөрийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах цогц төлөвлөгөөг агуулга, хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, баталсан байх.

(ii) Хөтөлбөрийн санхүүжилтийн хоёр дахь удаа Зарцуулалт хийхийн өмнө Монголын МСС нь Мониторинг, үнэлгээний цогц төлөвлөгөөг агуулга, хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, баталсан байх.

(iii) Аливаа үйл ажиллагааны хүрээнд Хөтөлбөрийн санхүүжилтээс Хэрэгжүүлэгч байгууллагад зарцуулалт гаргахын өмнө Монголын мянганы сорилтын сан нь уг хэрэгжүүлэгч байгууллага болон Монголын мянганы сорилтын сангийн хооронд байгуулсан хэрэгжүүлэгч байгууллагын гэрээг Мянганы сорилтын Корпорацид ирүүлэх үүрэгтэй бөгөөд уг гэрээ нь МСК-ийн шаарддаг хэлбэр, агуулгад нийцсэн байх ёстой.

(iv) Аливаа Үйл ажиллагааны хүрээнд тодорхой нэг ажил эсхүл барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний төлбөр төлөхтэй холбоотой эхний Зарцуулалтыг Хөтөлбөрийн санхүүжилтээс гаргахын өмнө Монголын МСС нь тухайн Төсөл, Үйл ажиллагаатай холбоотой БОНННУ, БОНМТ болон/эсхүл НСҮАТ зэрэг баримт бичиг тус бүрийг Монголын МСС, эсхүл Засгийн газрын холбогдох байгууллага агуулга, хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, баталсан тухай нотолгоог МСК-д илгээсэн байх.

(v) Аливаа Үйл ажиллагааны хүрээнд тодорхой нэг ажил эсхүл барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний төлбөр төлөхтэй холбоотой эхний Зарцуулалтыг Хөтөлбөрийн санхүүжилтээс гаргахын өмнө Монголын МСС нь БОНННУ, БОНМТ, эсхүл НСҮАТ-нд туссан холбогдох шаардлагуудыг МСК-ийн Байгаль орчны зааварчилгаа (болон түүнд ишлэл болгон оруулсан ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартууд)-д бүх талаар нийцүүлэн хэрэгжүүлж буй тухай нотолгоог агуулга, хэлбэрийн хувьд МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, МСК-д хүргүүлсэн байх.

(vi) Компакт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 (тав) дахь жил эхэлснээр Хөтөлбөрийн санхүүжилтээс хийх аливаа Зарцуулалтын өмнө Засгийн газар нь Хөтөлбөрийн хаалтын төлөвлөгөөний эхний хувилбарыг МСК-ийн Хөтөлбөрийн хаалтын зааварчилгаанд нийцүүлэн боловсруулж, МСК-д хүргүүлсэн байх.

(vii) Хөтөлбөрийн санхүүжилтээс тухай бүр Зарцуулалт хийхийн өмнө Засгийн газар нь Зардал нөхөх төлөвлөгөөг идэвхтэйгээр хэрэгжүүлж, сахин мөрдөж байгаа тухай нотолгоог МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, хүргүүлсэн байх.

(viii) Хөтөлбөрийн санхүүжилтээс тухай бүр Зарцуулалт хийхийн өмнө Засгийн газар нь Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөг идэвхтэйгээр хэрэгжүүлж, сахин мөрдөж байгаа тухай нотолгоог МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, хүргүүлсэн байх.

В ХЭСЭГ. Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаанд тавигдах Урьдчилсан болзолт нөхцөл.

(i) Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаатай холбоотойгоор Хөтөлбөрийн санхүүжилтээс тухай бүр Зарцуулалт хийхийн өмнө Засгийн газар нь шинэ ТЦБ-ийг Компакт гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш дөрөв дэх жилд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж буй тухай нотолгоог МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, хүргүүлсэн байх.

С ХЭСЭГ. Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаанд тавигдах Урьдчилсан болзолт нөхцөл.

(i) Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаатай холбоотойгоор Хөтөлбөрийн санхүүжилтээс тухай бүр Зарцуулалт хийхийн өмнө Засгийн газраас В(i) дэх хэсэгт заасан Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаанд тавигдах урьдчилсан болзолт нөхцөлтэй мөн адил нөхцөлийг хангасан байх.

Д ХЭСЭГ. Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаанд тавигдах Урьдчилсан болзолт нөхцөлүүд.

(i) Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагаанд тавигдах урьдчилсан болзолт нөхцөлүүд

(А) Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэх, харьцангуй бага цар хүрээ бүхий аливаа ажилтай холбогдуулан Хөтөлбөрийн санхүүжилтээс эхний Зарцуулалт хийхийн өмнө Засгийн газар нь шаардлагатай үнэлгээ, нарийвчилсан судалгаа, үйл ажиллагааны зардлын тооцоолол, тендерийн баримт бичиг боловсруулах зэрэг үйл ажиллагаанд шаардлагатай мэргэжлийн, байгаль орчны, газар

чөлөөлөлт, нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааны талаарх болон холбогдох бусад баримт мэдээллийг хүргүүлсэн байх.

(B) Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэх, харьцангуй бага цар хүрээ бүхий аливаа ажилтай холбогдуулан Хөтөлбөрийн санхүүжилтээс эхний Зарцуулалт хийхийн өмнө Засгийн газар нь энэхүү дэд үйл ажиллагааг хэрэгжүүлснээр (i) цомхтголд өртөх ажилчдыг өөр ажлын байрны шаардлагад тохируулан дахин сургах болон авч болох өөр бусад арга хэмжээний хувилбаруудыг тусгасан, (ii) олон тооны ажлын байр цомхтгол өртөж болзошгүй асуудлыг шийдвэрлэх зорилгоор МСК-ийн Жендэрийн бодлого, ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 2: Хөдөлмөр ба ажиллах нөхцөлд нийцүүлэн боловсруулсан төлөвлөгөө ("**ГС2-ын шаардлагыг биелүүлэх төлөвлөгөө**")-г тус тус МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, хүргүүлсэн байх. Энэхүү төлөвлөгөө нь цомхтголд өртсөн ажилтан болон тухайн байгууллага хооронд хийсэн зөвлөлдөх үйл явц болон тэрхүү үйл явц нь холбогдох хамтын гэрээ, хэлэлцээрийг баримталж буй эсэхийг баримтжуулсан байна.

(C) Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэх, харьцангуй бага цар хүрээ бүхий аливаа ажилтай холбогдуулан Хөтөлбөрийн санхүүжилтээс эхний Зарцуулалт хийхийн өмнө Засгийн газар нь ГС2-ын шаардлагыг биелүүлэх төлөвлөгөөг идэвхтэйгээр хэрэгжүүлж, сахин мөрдөж байгаа тухай нотолгоог МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, хүргүүлсэн байна.

(ii) Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагаанд тавигдах урьдчилсан болзолт нөхцөл. Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагааны хүрээнд үндсэн хөрөнгийн менежментийг сайжруулах зорилтот техникийн туслалцаатай холбогдуулан Хөтөлбөрийн санхүүжилтээс эхний зарцуулалт хийхийн өмнө Засгийн газар нь УСУГ "AquaRating" үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд өмнө нь харилцан тохиролцсон гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийн дагуу хөндлөнгийн хяналтын эхний багц үнэлгээг хүлээн авсан тухай нотолгоог МСК-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, хүргүүлсэн байх.

(iii) Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд үйл ажиллагаанд тавигдах урьдчилсан болзолт нөхцөлүүд. Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд үйл ажиллагааны хүрээнд усны чанарыг шалгах багаж, тоног төхөөрөмжийг худалдан авахтай холбогдуулан Хөтөлбөрийн санхүүжилтээс эхний зарцуулалт хийхийн өмнө, Засгийн газар нь Засгийн газрын аль нэг байгууллагын харьяанд байх усны чанарын лабораторид тохирох хэмжээ бүхий барилгаар хангасан байх ба аль байгууллагын харьяанд байхыг Засгийн газар болон МСК өмнө нь харилцан зөвшөөрсөн байна.

III ХАВСРАЛТ
ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛАХ ХУВЬ ХЭМЖЭЭ

| Засгийн газрын оруулах хувь хэмжээ (сая ам.доллороор) | | | | | | | |
|---|------------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|---------------|
| Бүрэлдэхүүн | Суурь он (2019) | 1-р жил | 2-р жил | 3-р жил | 4-р жил | 5-р жил | Нийт |
| 1. Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа | - | 5.93 | 5.93 | 11.85 | 11.85 | 23.70 | 59.26 |
| 2. Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагаа | - | 5.25 | 5.25 | 10.50 | 10.50 | 21.00 | 52.50 |
| Нийт дүн | - | 11.18 | 11.18 | 22.35 | 22.35 | 44.70 | 111.76 |

IV ХАВСРАЛТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛАХ ХУВЬ ХЭМЖЭЭГ ЗАРЦУУЛАХ ЗАРЧИМ

A. Ерөнхий зарчмууд.

1. Талууд бичгээр өөрөөр тохиролцоогүй бол Засгийн газрын оруулах хувь хэмжээ нь Компакт гэрээ, Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд МСК-ийн санхүүжилттэй холбогдуулан тавьсантай нэгэн адил зүйл заалтыг мөрдөж, шаардлагуудыг хангана. Аливаа эргэлзээгүй байх үүднээс, Засгийн газрын оруулах хувь хэмжээнээс бүхэлд нь болон хэсэгчлэн санхүүжүүлж хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагаа нь Хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны зааварчилгаа, МСК-ийн Байгаль орчны зааварчилгаа, Нийгэм, жендерийн асуудлыг Төсөл, Үйл ажиллагаанд тусгах төлөвлөгөөнд нийцсэн байна.
2. Засгийн газрын оруулах хувь хэмжээ нь Монгол Улсын Засгийн газар ямарваа нэг нөхцөлгүйгээр гаргах санхүүжилт байх бөгөөд Компакт гэрээ хэрэгжих хугацаанд Компакт гэрээний дагуу зөвшөөрсөн аливаа зориулалтаар ашиглагдаж болно.
3. Засгийн газрын оруулах хувь хэмжээг III Хавсралтад заасан жилээс эхлэн Эрх бүхий төлөөлөгч рүү шилжүүлж эхэлнэ. Тухайн санхүүгийн жилд ашиглагдаагүй үлдэгдэл хөрөнгийг дараагийн жил рүү шууд шилжүүлэх бөгөөд Компакт гэрээний хүрээнд ашиглахад бэлэн байлгана. Компакт гэрээний хугацаа дуусахад Засгийн газрын оруулах хувь хэмжээг зарцуулж дуусаагүй тохиолдолд энэхүү үлдэгдэл хөрөнгийг Компакт гэрээний Төслийн Зорилтуудын тогтвортой байдлыг хангахад ашиглахаар МСК болон Засгийн газар зорьж байгаа болно.

B. Засгийн газрын оруулах хувь хэмжээний Зарцуулалтад баримтлах зарчмууд

1. Засгийн газрын оруулах хувь хэмжээг зохих ёсоор зарцуулж удирдахын тулд эрх бүхий төлөөлөгч нь Засгийн газрын оруулах хувийн зарцуулалтыг хийх төрийн сангийн холбогдох данснаас зарцуулалт хийх эрхтэй байна (“Засгийн газрын данс”).
2. Эрх бүхий төлөөлөгчийн зохих хүсэлтийг хүлээн авмагц Засгийн газраас жил бүр Засгийн газрын дансанд Засгийн газрын оруулах хувийг шилжүүлнэ.
3. Засгийн газрын оруулах хувьд бий болсон аливаа хүү нь Засгийн газрын дансанд хэвээр хадгалагдах бөгөөд Монголын мянганы сорилтийн сангийн Сангийн яамнаас хүсэх дараагийн хүсэлтээс хасагдаж тооцогдоно

С. Засгийн газрын оруулах хувь хэмжээнд хяналт тавих

1. Монголын МСС нь Засгийн газрын оруулах хувь хэмжээг Хэрэгжилтийн төлөвлөгөөний баримт бичгүүдэд цаг тухайд нь, бүрэн хэмжээгээр, МСК-ийн шаардлагад нийцэхүйц байдлаар тусгах нөхцөлийг хангана.
2. Монголын МСС нь Засгийн газрын оруулах хувь хэмжээг МСК-ийн санхүүжилтийн нэгэн адил Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөө, Аудитын төлөвлөгөөнд дурдагдсан шаардлага, нөхцөлд нийцүүлнэ.

V ХАВСРАЛТ ТАТВАРЫН ХУВААРЬ

Монголын МСС болон бүх Нийлүүлэгчид, Аудитад хамрагдах нийлүүлэгчид, Хэрэгжүүлэгч байгууллагууд, Гүйцэтгэгчид (үндсэн болон туслан гүйцэтгэгч), зөвлөхүүд болон Компакт гэрээг хэрэгжүүлэх хүрээнд МСК-ийн санхүүжилтийг шууд болон шууд бусаар хүлээн авч байгаа аливаа бусад хуулийн этгээд, хувь хүн нь МСК-ийн санхүүжилтийг зарцуулахдаа Компакт гэрээний 2.8 дахь хэсэгт заасны дагуу татвараас чөлөөлөгдөх, эсхүл төлсөн хэмжээний татварын орлогыг нөхөн төлүүлж буцаан авах нөхцөлөөр Засгийн газар бүрэн хангана.

Компакт гэрээний дагуу зарим тодорхой Татвар, тэдгээрээс чөлөөлөх механизмыг дор дурдсан Хуваариудад заасан. Засгийн газар нь татварын байгууллагуудыг Компакт гэрээнд заасан нөхцөл, шаардлага болон энэхүү Гэрээнд харилцан тохиролцсон татвараас чөлөөлөх механизмыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах зорилгоор тодорхой заавар бүхий албан бичгийг Компакт гэрээний хуулбар, эдгээр Хуваарийн хамт Монгол Улсын Татварын ерөнхий газар (**“ТЕГ”** гэх) болон Татварын орлогыг татан төвлөрүүлэхэд оролцдог төвийн болон орон нутгийн холбогдох бүх эрх бүхий байгууллагууд (нийтэд нь **“Татварын байгууллагууд”** гэх)-д хүргүүлнэ.

Монголын МСС нь Нийлүүлэгчид, Аудитад хамрагдах нийлүүлэгчид, Хэрэгжүүлэгч байгууллагууд, Гүйцэтгэгчид (үндсэн болон туслан гүйцэтгэгч), зөвлөхүүд болон Компакт гэрээг хэрэгжүүлэх хүрээнд МСК-ийн санхүүжилтийг шууд болон шууд бусаар хүлээн авч байгаа аливаа бусад хуулийн этгээд, хувь хүн зэрэг татвараас чөлөөлөгдөх эрх бүхий бүх этгээдэд Татвараас чөлөөлөгдөх, төлсөн татварыг нөхөн төлүүлэх чиглэлээр зохих туслалцаа, дэмжлэгийг үзүүлж ажиллана.

Нэг гүйлгээтэй холбоотойгоор нэгээс олон тооны татвараас чөлөөлөгдөх, эсхүл буцаан олгуулах шаардлагатай бол тус бүрт нь хүсэлт гаргах, тайлбар хийх шаардлагагүй (тухайлбал, нэг ижил бараа, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар (**“НӨАТ”** гэх), онцгой албан татвар, гаалийн хураамж г.м).

Дараах жагсаалтад дурдсан Татваруудаас чөлөөлөх буюу нөхөн төлнө.

| Хуваарь | Татвар | Механизм |
|---------|---|----------|
| A | Нэмэгдсэн өртгийн албан татвар (улсын татвар) | |
| B | Бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсаны НӨАТ (Улсын татвар) | |
| C | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (Улсын татвар) | |
| D | Хувь хүний орлогын албан татвар (улсын татвар) | |
| E | Нийгмийн даатгал | |
| F | Ажлын байрны төлбөр | |

А ХУВААРЬ
НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР (УЛСЫН ТАТВАР)

Татвараас чөлөөлөх эрх зүйн үндэслэл

1. Компакт гэрээний 2.8 дахь хэсэг
2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай 2015 оны хууль (**“НӨАТ-ын тухай хууль”** гэх)-ийн 13.1.3 дахь заалт

Татвараас чөлөөлөгдөх этгээд

1. Монголын МСС
2. Бүх Нийлүүлэгчид, Аудитад хамрагдах нийлүүлэгчид, Хэрэгжүүлэгч байгууллагууд, Гүйцэтгэгчид (үндсэн болон туслан гүйцэтгэгч), зөвлөхүүд болон Компакт гэрээг хэрэгжүүлэх хүрээнд МСК-ийн санхүүжилтийг шууд болон шууд бусаар хүлээн авч байгаа аливаа бусад хуулийн этгээд, хувь хүн (хуулийн этгээд бол **“Чөлөөлөгдсөн байгууллага,”** хувь хүн бол **“Чөлөөлөгдсөн хувь хүн”** гэх)

Татвараас чөлөөлөхөд баримтлах журам

1. НӨАТ шингэсэн дотоодын худалдан авалтыг татвараас чөлөөлөх (дотоодод үйлдвэрлэсэн, эсхүл дотоодын этгээдээс худалдан авсан импортын болон бусад барааг оролцуулан). Компакт гэрээг хэрэгжүүлэх хүрээнд, НӨАТ-ын тухай хуулийн дагуу НӨАТ ногдуулахаар заасан бараа бүтээгдэхүүнийг дотоодоос худалдан авсан бол борлуулагч нь тэрхүү худалдан авалтыг НӨАТ-аас чөлөөлж болно. Татвараас ийнхүү чөлөөлөх боломжийг бүрэн ашиглахын тулд худалдан авагч буюу Монголын МСС, Чөлөөлөгдсөн байгууллага, эсхүл Чөлөөлөгдсөн хувь хүний аль нэг нь НӨАТ-аас чөлөөлөгдөх худалдан авалтын бүртгэлийн дугаар (**“Татвараас чөлөөлөгдөх бүртгэлийн дугаар”** гэх)-ыг ашиглана.
2. Тухайн улирлын эхний сарын эхний тав хоногийн дотор Гадаад харилцааны яам нь Сангийн сайдын 2016 оны 46 дугаар тушаалд заасан журмын дагуу Татвараас чөлөөлөгдөх бүртгэлийн дугаар хүссэн албан бичгийг холбогдох бусад баримт бичгийн хамт Сангийн яаманд хүргүүлнэ. Гадаад харилцааны яам нь Чөлөөлөгдөх хуулийн этгээд, хувь хүмүүсийн нэрс болон тэдгээр хуулийн этгээд, хувь хүмүүс тус бүрийн татвараас чөлөөлүүлэхээр хүссэн бараа бүтээгдэхүүний жагсаалтыг баталж, хавсарган Сангийн сайдад хүргүүлнэ.
3. Дээрх хүсэлт болон холбогдох баримт бичгийг хянан үзсэний үндсэн дээр Сангийн сайд тухайн улирлын эхний сарын эхний 15 хоногт багтаан хүсэлтийг батална. Батлагдсан жагсаалтыг Сангийн яамнаас ажлын тав хоногийн дотор Татварын ерөнхий газарт хүргүүлнэ.
4. Татварын ерөнхий газар Татвараас чөлөөлөгдөх бүртгэлийн дугаар олгож, нэвтрэх эрх өгөх бөгөөд холбогдох мэдээллийг Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системд оруулна.

В ХУВААРЬ

БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ИМПОРТООР ОРУУЛСАНЫ НӨАТ ИМПОРТ БОЛОН ГААЛИЙН ХУРААМЖ (УЛСЫН ТАТВАР)

Татвараас чөлөөлөх эрх зүйн үндэслэл

1. Компакт гэрээний 2.8 дахь хэсэг
2. НӨАТ-ын тухай хууль
3. Гаалийн тариф, албан татварын тухай хуулийн 38.1.2 дахь заалт

Татвараас чөлөөлөгдөх этгээд

1. Монголын МСС
2. Чөлөөлөгдсөн байгууллага болон Чөлөөлөгдсөн хувь хүн тус бүр

Татвараас чөлөөлөхөд баримтлах журам

1. Хил дээр НӨАТ болон гаалийн хураамжаас чөлөөлөгдөх асуудлыг Сангийн сайдын 2015 оны 317 дугаар тушаалаар зохицуулна.
2. Гадаад харилцааны яам нь дээр дурдсан журмын дагуу хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт Сангийн яаманд хүргүүлэх бөгөөд хавсаргах баримт бичгийн жагсаалтыг Сангийн сайдын 2015 оны 317 дугаар тушаалаар батлагдсан журамд тусгасан болно. Ийнхүү хүргүүлсэн хүсэлт болон холбогдох баримт бичгийг шаардлага хангасан гэж үзвэл Сангийн яамны НӨАТ болон гаалийн хураамжаас чөлөөлөх асуудал хариуцсан мэргэжилтэн нь Бүртгэлийн хуудас олгоно (Сангийн сайдын 2015 оны 317 дугаар тушаалын Хавсралт 1).
3. Сангийн яамны НӨАТ болон гаалийн хураамжаас чөлөөлөх асуудал хариуцсан мэргэжилтэн нь Бүртгэлийн хуудаст хоёрдугаар гарын үсэг зурах бөгөөд холбогдох газар, хэлтсийн дарга нь нэгдүгээр гарын үсэг зурна. НӨАТ болон гаалийн хураамжаас чөлөөлсөн Бүртгэлийн хуудасны эх хувьд үндэслэн Гаалийн ерөнхий газар нь тэрхүү бараа бүтээгдэхүүнийг бүртгэж, НӨАТ, гаалийн хураамжаас чөлөөлнө. Гадаад харилцааны яамны хүсэлт, Бүртгэлийн хуудас болон холбогдох бусад бүх мэдээллийг цахим системд бүрэн оруулсан байна.

С ХУВААРЬ
АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Татвараас чөлөөлөх эрх зүйн үндэслэл

1. Компакт гэрээний 2.8 дахь хэсэг

Татвараас чөлөөлөгдөх этгээд

1. Монголын МСС
2. Хөтөлбөртэй холбоотой ажил гүйцэтгэж буй Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдээс бусад бүх хуулийн этгээд (зөвхөн Хөтөлбөртэй холбогдуулан олсон орлогод хамаарна).

Татвараас чөлөөлөхөд баримтлах журам

1. Монголын МСС нь Хөтөлбөртэй холбоотой аливаа ажил гүйцэтгэж буй хуулийн этгээдийн Татвараас чөлөөлөгдсөн тухай бүртгэлийг хөтлөх бөгөөд татварын тухай дотоодын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Татварын ерөнхий газарт тайлагнах үүрэгтэй.
2. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн хувьд Монголын МСС нь суутган татвар төлөгч байна. Суутган татварыг төвлөрүүлэх, шийдвэрлэх, тайлагнах үйл ажиллагаа нь Татварын тухай дотоодын хууль тогтоомжтой нийцсэн байна.

Д ХУВААРЬ
ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Татвараас чөлөөлөх эрх зүйн үндэслэл

1. Компакт гэрээний 2.8 дахь хэсэг

Татвараас чөлөөлөгдөх этгээд

1. Монголын МСС
2. Хөтөлбөртэй холбоотой ажил гүйцэтгэж буй Монгол Улсын иргэн, эсхүл байнгын оршин суугчаас бусад хувь хүн (зөвхөн Хөтөлбөртэй холбогдуулан олсон орлогод хамаарна).

Татвараас чөлөөлөхөд баримтлах журам

1. Монголын МСС нь Хөтөлбөртэй холбоотой аливаа ажил гүйцэтгэж буй хувь хүний Татвараас чөлөөлөгдсөн тухай бүртгэлийг хөтлөх бөгөөд татварын тухай дотоодын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Татварын ерөнхий газарт тайлагнах үүрэгтэй.
2. Монгол Улсын иргэн, байнгын оршин суугчийн хувьд Монголын МСС нь суутган татвар төлөгч байна. Суутган татварыг төвлөрүүлэх, шийдвэрлэх, тайлагнах үйл ажиллагаа нь Татварын тухай дотоодын хууль тогтоомжтой нийцсэн байна.

Татвараас чөлөөлөх эрх зүйн үндэслэл

1. Компакт гэрээний 2.8 дахь хэсэг

Татвараас чөлөөлөгдөх этгээд

- a. Монголын МСС
- b. Хөтөлбөртэй холбоотой ажил гүйцэтгэж буй Монгол Улсын иргэн, эсхүл байнгын оршин суугчаас бусад хувь хүн (зөвхөн Хөтөлбөртэй холбогдуулан олсон орлогод хамаарна).
- c. Хөтөлбөртэй холбоотой ажил гүйцэтгэж буй бүх хуулийн этгээд (зөвхөн өөрийн ажилтан-гадаадын иргэнтэй холбоотой нийгмийн даатгалын шимтгэл төлөх зардал).

Татвараас чөлөөлөхөд баримтлах журам

1. Хөтөлбөртэй холбоотой аливаа ажил гүйцэтгэж буй хуулийн этгээд, хувь хүн нь тодорхой гадаадын иргэнийг нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс чөлөөлөхийг дэмжсэн албан бичиг гаргаж өгөх хүсэлтийг Монголын МСС-д хандан гаргана.
2. Монголын МСС нь Хөтөлбөртэй холбоотой аливаа ажил гүйцэтгэж буй гадаадын иргэнийг нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс чөлөөлөхийг дэмжсэн албан бичгийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.
3. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Монголын МСС, холбогдох нийгмийн даатгалын газар/хэлтэс, татварын байгууллага болон бусад холбогдох байгууллагад нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлж байгаа талаар мэдэгдэнэ.

F ХУВААРЬ
АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨР

Төлбөрөөс чөлөөлөх эрх зүйн үндэслэл

1. Компакт гэрээний 2.8 дахь хэсэг
2. Ажиллах хүч гадаадад гаргах, ажиллах хүч, мэргэжилтэн гадаадаас авах тухай 2001 оны хуулийн 9.5 дахь хэсэг
3. “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоол (Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөх, чөлөөлөх тухай)

Төлбөрөөс чөлөөлөгдөх этгээд

1. Монголын МСС
2. Хөтөлбөртэй холбоотой аливаа ажил гүйцэтгэж буй Монгол Улсын иргэн, эсхүл байнгын оршин суугчаас бусад хувь хүн
3. Хөтөлбөртэй холбоотой ажил гүйцэтгэж буй бүх хуулийн этгээд (зөвхөн өөрийн ажилтан-гадаадын иргэнтэй холбоотой ажлын байрны төлбөр төлөх зардал).

Төлбөрөөс чөлөөлөхөд баримтлах журам

1. Хөтөлбөртэй холбоотой ажил хийж буй хуулийн этгээд, хувь хүн нь тодорхой гадаадын иргэнийг ажлын байрны төлбөр төлөхөөс чөлөөлөхийг дэмжсэн албан бичиг гаргаж өгөх хүсэлтийг Монголын МСС-д хандан гаргана.
2. Монголын МСС нь Хөтөлбөртэй холбоотой ажил гүйцэтгэж буй гадаадын иргэнийг ажлын байрны төлбөр төлөхөөс чөлөөлөхийг дэмжсэн албан бичгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлнэ.
3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Монголын МСС, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар, Татварын байгууллага болон бусад холбогдох байгууллагад ажлын байрны төлбөрөөс чөлөөлж байгаа талаар мэдэгдэнэ.